



**Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай
конвенц**

**Тэгш хамрагдан сурч боловсрох эрхийн талаарх
Ерөнхий зөвлөмж No. 4 (2016)**

Монгол Улс, Улаанбаатар хот

2024 он



Энэхүү гарын авлагыг Европын Холбооны хамтын санхүүжилтээр хэрэгжиж буй "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн зөрчилд хариу үзүүлэх үр нөлөөг сайжруулахад Иргэний нийгмийн байгууллагуудын хувь нэмэр" (NDICI HR/2023/451-474) төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 300 хувь хэвлэв.

Гарын авлагын агуулга нь Европын Холбооны үзэл санааг илэрхийлээгүй болно.

2024 он



Энэхүү гарын авлагын орчуулгыг НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо орчуулав.

ISBN....

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын Конвенц (2006)

24 дүгээр зүйл

Боловсрол

1. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг ямар нэг алагчлалгүй, тэгш боломжийн үндсэн дээр эдлүүлэх үүднээс Оролцогч улсууд нь дараах зорилгод чиглэсэн бүх түвшинд тэгш хамруулан сургах болон насан туршийн боловсролын тогтолцоог бий болгоно:

а) хүний чадвар, эрхэм зэргийн мэдрэмж болон өөрийгөө үнэлэх үнэлэмжийг бүрэн дүүрэн хөгжүүлж, хүний эрх, үндсэн эрх чөлөө болон хүний ялгаатай байдлыг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх;

б) хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийн шинж чанар, авьяас чадвар, бүтээлч чанар болон тэдний оюуны болон бие махбодын чадварыг байж болох хамгийн дээд хэмжээгээр хөгжүүлэх;

в) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг чөлөөт нийгэмд үр дүнтэйгээр оролцох боломжийг олгох.

2. Эдгээр эрхийг хэрэгжүүлэх үүднээс Оролцогч улсууд нь дараах зүйлүүдийг баталгаажуулна:

а) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн бэрхшээлийнх нь улмаас ерөнхий боловсролын тогтолцоонд хамруулахгүй байх, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хөгжлийн бэрхшээлийнх нь улмаас үнэ төлбөргүй, заавал эзэмших ёстой бага болон дунд боловсрол олгох үйл ажиллагаанд хамруулахгүй байх явдлаас сэргийлэх;

б) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь өөрсдийн амьдарч буй орчиндоо бусдын нэгэн адил тэгш байх үндсэн дээр тэгш хамруулсан, чанартай мөн үнэ төлбөргүйгээр бага болон дунд боловсролыг эзэмших;

в) хувь хүний онцлог шаардлагад нийцсэн тохирох хэрэглэгдэхүүнээр хангах;

д) ерөнхий боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд үр дүнтэй сурч боловсрохын шаардлагатай дэмжлэг туслалцааг авах;

е) Бүрэн дүүрэн хамруулах зорилгыг биелүүлэхийн тулд академийн болон нийгмийн хөгжлийг дээд хэмжээнд хүргэх орчинд хувь хүнд зориулсан үр дүнтэй дэмжлэг туслалцааны арга хэмжээг авах.

3. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм, хамт олны гишүүний хувьд боловсролд бүрэн дүүрэн, тэгш оролцоход нь дэмжлэг үзүүлэх амьдралын болон нийгмийн хөгжлийн ур чадваруудыг эзэмших боломжийг олгоно. Үүний тулд Оролцогч улсууд нь дараах зүйлийг оролцуулан тохирох арга хэмжээнүүдийг авна:

а) Брайль үсэг, өөр альтернатив бичлэг, болон харилцааны нэмэлт болон альтернатив арга, төрөл хэлбэр, бусад хэв маяг, түүнчлэн орон зайн чиг баримжаа болон хөдөлгөөн дэмжих ур чадвар эзэмшүүлэх, үе тэнгийнхэн болон зөвлөгч нараас үзүүлэх туслалцаанд дэмжлэг үзүүлэх;

б) Дохионы хэл сурах болон сонсголгүй хүмүүсийн хэл ярианы өвөрмөц онцлогийг илэрхийлсэн хэл зүйн аргыг хөхиүлэн дэмжих;

с) Академийн болон нийгмийн хөгжлийг дээд хэмжээнд хүргэх орчинд хүмүүс, ялангуяа хараагүй, сонсголгүй, хараагүй-сонсголгүй хүүхдүүдэд олгох боловсролыг тухайн хүний онцлогт нийцсэн хамгийн зохистой хэл яриа, харилцааны арга, төрөл хэлбэр, бусад хэв маягаар олгох явдлыг хангах.

4. Эдгээр эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Оролцогч улсууд нь багш нар, ялангуяа брайль үсэг эсхүл дохионы хэл эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй багш нарыг ажиллуулж, боловсролын бүх түвшинд ажилладаг ажилтан, мэргэжилтнүүдийг сургах зохистой арга хэмжээ авна. Ийм сургалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, харилцааны нэмэлт болон альтернатив арга, төрөл хэлбэр, бусад хэв маяг болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслах боловсролын заах арга зүй, сургалтын материал хэрэглэх явдлыг хамруулна.

5. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил тэгш, алагчлахгүй байх үндсэн дээр дээд боловсрол, мэргэжлийн сургалт, насанд хүрэгсдийн болон насан туршийн боловсрол эзэмших явдлыг хангана. Эл зорилгоор Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тохирох хэрэглэгдэхүүнээр хангах явдлыг баталгаажуулна.

**Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай
конвенц**

Түгээх.: Ерөнхий

2016 оны 11 дүгээр сарын 25

Эх хувь: Англи хэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо**Тэгш хамрагдан сурч боловсрох эрхийн талаарх 2016 оны
Ерөнхий зөвлөмж No. 4****I. Оршил**

1. Урт хугацааны туршид халамж хүртэгч хэмээн тодорхойлогдож ирсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өнөө үед ямарваа нэгэн ялгаварлан гадуурхалтгүйгээр, тэгш боломжийн үндсэн дээр сурч боловсрох эрхээ шаардах эрх эдлэгч гэж олон улсын эрх зүйн хүрээнд хүлээн зөвшөөрсөн юм. Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989), Бүх нийтийн боловсролын тухай дэлхийн тунхаглал (1990), Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан боломжийг тэгш байдлаар бүрдүүлэх тухай стандарт дүрэм (1993), Саламанкагийн тунхаглал, үйл ажиллагааны хүрээ (1994) зэрэг баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурч боловсрох эрхийг танин мэдэж, ойлголт нэмэгдэж байгааг илтгэсэн арга хэмжээнүүдийг тусгасан билээ.

2. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд сурч боловсрох эрхийг эдлүүлэх гол түлхүүр бол тэгш хамруулахуй гэж хүлээн зөвшөөрөх явдал улам өргөжиж, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод чанартай тэгш хамран сургах боловсролын тухай ойлголтыг оруулснаар заавал биелүүлэх шинжтэй олон улсын гэрээгээр баталгаажуулсан анхны тохиолдол болсон байна. Мөн Тогтвортой хөгжлийн зорилго - 4 нь тэгш хамруулсан, чанартай, эрх тэгш боломжоор хангасан боловсролын үнэ цэнийг дахин баталгаажуулжээ. Тэгш хамран сургах боловсрол нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг оролцуулан бүх суралцагчдад чанар сайтай боловсрол олгох төдийгүй тэгш хамруулсан, амар амгалан, шударга нийгмийг цогцлоох үндэс болно. Цаашилбал өргөн цар хүрээтэй боловсрол, нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийг авчирна. НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурч боловсрох эрхийн тухай сэдэвчилсэн тайланд тусгаснаар гагцхүү тэгш хамран сургах боловсрол нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чанартай боловсрол, нийгмийн хөгжлийг нэгэн

зэрэг хангаж, сурч боловсрох эрхийн түгээмэл болон үл ялгаварлах шинжийг баталгаажуулах ажээ.¹

3. Ахиц дэвшил гарч байгаа хэдий ч даван туулбал зохих хүнд хэцүү сорилт бэрхшээл байсаар байгаад Хорооны зүгээс санаа зовниж байна. Хөгжлийн бэрхшээлтэй олон сая хүн сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй байгаа бөгөөд түүнээс ч олон хүн өөрсдийн үе тэнгийнхнээсээ тусгаарлагдсан боловсролын орчинд сурах, чанараар доогуур боловсрол эзэмшихээс өөр аргагүй байдалд байна.

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэгш хамрагдан сурч боловсроход тулгарч байгаа саад тогторыг хэд хэдэн хүчин зүйлс бүрдүүлж байна. Үүнд:

(a) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гадуурхахад хүрдэг хувь хүний чадвар алдалтаас илүүтэйгээр тухайн хамт олон, нийгэм дэх саад тогторт анхаарч, хөгжлийн бэрхшээлийн тухай хүний эрхийн загварыг ойлгож эсвэл хэрэгжүүлж чадахгүй байх;

(b) Тусгай байгууламжид урт хугацаагаар тусгаарлан амьдруулах, нийтийн үйлчилгээнд хамрагдсан тохиолдолд доогуур хүлээлт тавих, ташаа бодол, айдастай огт тэмцэхгүй байх эсвэл улам нэмэх зэргээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг байнга ялгаварлан гадуурхах;

(c) Өрсөлдөөнт байдал, нэг ч хүүхдийг үлдээлгүй сургах зэргийг багтаасан ялгаатай байдлын болон тэгш хамруулсан, чанартай боловсролын мөн чанар, давуу талын тухай мэдлэг ойлголтгүй байх; тухайлбал, бүх эцэг эхэд хүрч ажиллаж чадахгүй байх; шаардлагатай дэмжлэгийг үзүүлж чадахгүй байх нь тэгш хамруулах нь боловсролын чанарыг бууруулж, эсвэл бусдад сөрөг нөлөө үзүүлнэ гэсэн ташаа айдас, хэвшмэл ойлголтод хүргэх;

(d) Үр дүнтэй бодлого боловсруулах, тэгш хамруулсан, чанартай боловсролыг хөхиүлэн дэмжих арга хэмжээг авахад саад болдог (буюу эгэх хариуцлагатай байх, хөтөлбөр боловсруулахад нэгэн зэрэг шаардлагатай) нарийвчилсан задаргаатай тоон мэдээлэл, судалгаа хангалтгүй байх;

(e) Багшлах боловсон хүчнийг зохих түвшинд бэлтгээгүй байх гэх мэтээр тэгш хамрагдан сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн мэдлэг, чадавх, улс төрийн хүсэл зориг дутагдах;

(f) Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг тэгш хамруулахад шаардагдах тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангах болон хөшүүрэг бүхий санхүүжилтийн механизм, яамд хоорондын зохицуулалт, дэмжлэг, тогтвортой байдал хангалтгүй ба оновчгүй байх;

(g) Зөрчигдсөн эрхийг сэргээх, эрхийн зөрчлийн улмаас учирсан хохирлыг барагдуулах эрх зүйн механизмгүй байх.

¹ A/HRC/25/29, Corr.1-ийн 3, 68 дахь догол мөрийг үзнэ үү.

5. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын Оролцогч улсуудын зүгээс тэгш хамран сургах боловсрол олгох чиглэлээр арга хэмжээ авахдаа тус конвенцын суурь болсон ерөнхий зарчмыг анхаарч үзэх, тэгш хамран сургах боловсролын тогтолцоог бий болгох үйл явц, гарах үр дүнг уг гэрээний 3 дугаар зүйлтэй нийцүүлэхэд анхаарах ёстой.

6. Энэхүү ерөнхий зөвлөмж нь хөгжлийн бэрхшээлтэй гэж тогтоогдсон эсвэл хөгжлийн бэрхшээлтэй гэж тооцогдох хүн бүрд үйлчилнэ.² Хороо оюуны бэрхшээлтэй эсвэл хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй, сонсголгүй бөгөөд хараагүй, аутизмтай эсвэл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэх мэт зарим бүлэг боловсролын хувьд бусдаас илүү гадуурхагдах эрсдэлтэйг хүлээн зөвшөөрч байна.

7. Тус конвенцын 4 (3) дугаар зүйлийн дагуу Оролцогч улсууд тэгш хамран сургах боловсролын бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх бүхий л үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг төлөөллийн байгууллагаар нь дамжуулан зөвлөлдөх ба идэвхтэй оролцуулах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, шаардлагатай тохиолдолд тэдний гэр бүлийг зөвхөн боловсролын үйлчилгээ хүртэгч бус түншлэгч хэмээн хүлээн зөвшөөрөх ёстой.

II. 24 дүгээр зүйлийн хэм хэмжээний агуулга

8. Конвенцын 24 (1) дүгээр зүйлд нийцүүлэн Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсрол, мэргэжлийн сургалт, насан туршдаа суралцах, хичээлээс гадуурх болон нийтийг хамарсан үйл ажиллагаа зэрэг боловсролын бүх шат түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусадтай адил тэгш боломжийн үндсэн дээр, ямар нэгэн ялгаварлан гадуурхалтгүйгээр бүх суралцагчдад зориулсан тэгш хамран сургах боловсролын тогтолцоогоор дамжуулан бодит биелэл болгох ёстой.

9. Тэгш хамрагдан сурч боловсрох эрхийг баталгаажуулах нь суралцагч нэг бүрийн онцлог шинж, харилцан адилгүй эрэлт хэрэгцээ-шаардлагад тохируулах, тулгарч байгаа саад тотгоруудыг арилгах хүчин чармайлт нь албан болон албан бус боловсролын бүхий л орчинд тогтсон соёл, бодлого, өдөр тутамд хийж хэвшсэн практик үйл ажиллагааг хувирган өөрчлөхийг шаардана. Ингэснээр бүх суралцагчдад хүрч үйлчлэх боловсролын тогтолцооны чадавхыг улам нэмэгдүүлэх болно. Мөн бүх суралцагчдын, ялангуяа янз бүрийн шалтгаанаар тогтолцооны гадна гадуурхагдан үлдсэн эсвэл гадуурхагдах эрсдэлтэй суралцагчдын бүрэн дүүрэн, үр дүнтэй хамрагдалт, оролцоо, хүртээмж, ирц, амжилтад анхаардаг. Тэгш хамруулах гэдэгт ямар нэгэн ялгаварлан гадуурхалтгүйгээр чанар сайтай албан боловсрол эзэмших болон амьдралаас суралцах үйл явцад хамрагдах, боловсролын шат түвшнээр ахиж дэвшихийг хамруулж ойлгоно. Мөн тэгш хамруулах нь тогтолцоо,

² Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 1(2) дугаар зүйл.

бүтэц болон хамт олныг сөрөг нөлөө бүхий хэвшмэл ойлголт зэргээр илрэлээ олдог ялгаварлан гадуурхалттай тэмцэх, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, оролцоог хөхиүлэн дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын сайн сайхан байдал, амжилтад анхаарах замаар хүн бүрийн суралцах, оролцоход тулгарч байгаа саад тотгорыг даван туулахад тусалдаг. Энэ нь хууль тогтоомж, бодлого, боловсролын санхүүжилтийн механизм, удирдлага, загварчлал, боловсролын үйлчилгээ үзүүлэх, түүнийгээ хянаж үнэлэх үйл ажиллагааг, өөрөөр хэлбэл боловсролын тогтолцоог гүн гүнзгий хувирган өөрчлөхийг шаардана.

10. Тэгш хамран сургах боловсрол гэдэгт дараах зүйлсийг ойлгоно:

(a) Бүх суралцагчдын хувьд хүний үндсэн эрх. Тухайлбал, боловсрол бол хүүхдийн хувьд тухайн хувь суралцагчийн эдлэх эрх бөгөөд эцэг эх эсвэл асран хамгаалагчийн эрх биш. Иймээс хүүхдийн эрх эцэг эхийн үүрэг хариуцлагын өмнө тавигдана;

(b) Бүх суралцагчдын сайн сайхныг эн тэргүүнд тавьж, тэдний төрөлхийн эрхэм чанар, бие даасан байдлыг хүндэтгэж, нийгмийн амьдралд үр дүнтэй оролцох, хувь нэмрээ оруулах тухайн хүний чадвар чадамж болон хувь хүний зүгээс тавих шаардлагыг хүлээн зөвшөөрөх зарчим;

(c) Хүний бусад эрхээ эдлэх арга зам. Энэ бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийгөө ядуурлаас гаргах, өөрийн оршин суугаа нутгийн амьдралд бүрэн дүүрэн оролцох арга замыг олж харах, мөлжлөгөөс хамгаалагдах арга зам билээ.³ Мөн тэгш хамруулсан нийгэм бий болгох үндсэн арга зам болно;

(d) Сурч боловсрох эрхийг эдлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг арилгахад чиглэсэн тасралтгүй бөгөөд идэвхтэй үйл явцын төдийгүй бүх суралцагчийг үр дүнтэй тэгш хамруулах нөхцөл боломжийг бүрдүүлэх цаашлаад бодит байдал дээр бүрэн хамруулах чиглэлээр ердийн сургуулиудын хэвшмэл соёл, бодлого болон өдөр тутмын практик үйл ажиллагааг өөрчилснөөр хүрэх үр дүнг хэлнэ.

11. Хорооны зүгээс гадуурхах, тусгаарлах, интеграцчилах, тэгш хамруулах гэсэн ойлголтуудын хоорондын ялгааг хүлээн зөвшөөрөх нь ач холбогдолтойг цохон тэмдэглэж байна. Гадуурхах гэдэгт суралцагчид шууд болон шууд бусаар ямар нэгэн хэлбэрийн боловсрол эзэмшүүлэхээс татгалзах эсвэл түүнийг элсүүлэхгүй байхыг ойлгоно. Тусгаарлан сургах гэж хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг тэдний тодорхой нэг согог эсвэл хэд хэдэн төрлийн хавсарсан согогт хариу үйлдэл үзүүлэх байдлаар зохион байгуулсан тусгай орчинд хөгжлийн бэрхшээлгүй суралцагчдаас тусад нь боловсрол олгохыг хэлнэ. Интеграцчилан сургах гэдэгт нийтэд зориулсан боловсролын

³ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо, Сурч боловсрох эрхийн тухай Ерөнхий зөвлөмж No.13.

байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүнийг стандартчилсан шаардлагад нийцэн сурч чадна гэж ойлгон байршуулахыг ойлгоно.⁴ Тэгш хамруулан сургах гэдэгт тухайн насны бүх суралцагчдыг эрх тэгшээр хамтдаа суралцах туршлагатай болгож, тэдний давуу тал болон тавигдах шаардлагад хамгийн дээд зэргээр тохирсон орчинг бий болгож үйлчилнэ гэсэн алсын харааг хэрэгжүүлэхэд учрах саад тотгорыг даван туулахын тулд боловсролын агуулга, заах арга, хандлага-арга зүй, бүтэц, стратегидаа тодруулга өөрчлөлт, цогц өөрчлөлт оруулах замаар тогтолцооны шинэчлэл хийх үйл явцыг багтаана. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг ердийн сургуулийн ангид ямарваа нэгэн бүтцийн өөрчлөлт хийхгүйгээр, жишээлбэл зохион байгуулалт, хичээлийн хөтөлбөр, заах ба суралцах арга зүй, стратегид өөрчлөлт оруулахгүйгээр оруулан суулгасан бол тэгш хамруулж байна гэж үзэхгүй. Цаашилбал интеграцчилан сургах нь тусгаарлан сургахаас тэгш хамруулан сургахад шилжих баталгаа болохгүй.

12.Тэгш хамран сургах боловсролын үндсэн шинжид дараах зүйлс багтана:

(a) “Тогтолцоо бүхэлдээ” арга хандлага: Боловсролын яамд тэгш хамруулах боловсролыг хөгжүүлэх болон байгууллагынхаа хувьд соёл, бодлого, өдөр тутмынхаа практик үйл ажиллагаанд шаардлагатай өөрчлөлтийг хийхэд бүх нөөцөө дайчлан хөрөнгө оруулах ёстой;

(b) “Боловсролын орчныг иж бүрнээр” нь авч үзэх: Анги танхимд хичээл заах, хүмүүс хоорондын харилцаа, сургуулийн зөвлөл хуралдах, багшийн ажлыг хянаж үнэлэх, зөвлөх үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, сургуулийн аялал хийх, төсөв хуваарилах, хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй суралцагчийн эцэг эхтэй, шаардлагатай үед нутгийн иргэд эсвэл олон нийттэй ямар нэгэн байдлаар харилцах зэрэг бүхий л орчин нөхцөл, шат түвшинд соёл, бодлого, өдөр тутмынхаа практик үйл ажиллагаандаа шигтгэн тэгш хамран сургах боловсролыг бодит үйл хэрэг болгоход боловсролын байгууллагын манлайлагчдын сэтгэл зүтгэл амин чухал;

(c) “Хувь хүнийг цогцоор нь авч үзэх” хандлага: Хүн бүр сурах чадавхтайг хүлээн зөвшөөрч, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч зэрэг бүхий л суралцагчдад өндөр хүлээлт тавьдаг. Тэгш хамруулах боловсрол нь хоорондоо ялгаатай чадавх, шаардлага, суралцах хэв маягт тааруулсан уян хатан хичээлийн хөтөлбөр, заах ба сурах арга зүйг санал болгодог. Энэ хандлага нь дэмжлэг, тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангах, эрт оролцооны хөтөлбөрийг хэрэгжүүлэх тохиолдолд бүх суралцагч өөрийн чадамждаа тултал хөгжих боломжтой гэж үздэг. Хичээлээ төлөвлөхдөө агуулгаас илүүтэйгээр суралцагчдын чадавх, сэдэл, тэмүүлэлд анхаардаг. “Хувь хүнийг цогцоор нь авч үзэх” хандлага нь зохих дэмжлэг бүхий хүртээмжтэй суралцах орчинд тэгш

⁴ А/HRC/25/29 Согт.1-ийн 4 дэх догол мөр болон НҮБ-ын Хүүхдийн сан (НҮБХС), *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрх: Тэгш хамран сурах боловсролд хүний эрхэд суурилан хандах нь* (Женев хот, 2012) –г үзнэ үү.

хамруулан хичээл заах нөхцөлийг бүрдүүлснээр боловсролын орчинд тусгаарлан сургах байдлыг эцэслэхийг зорьдог. Суралцагчдыг боловсролын тогтолцоонд тааруулахыг хичээхээс илүүтэйгээр хүн нэг бүрд таарсан хариу үйлдлийг боловсролын тогтолцоо үзүүлэх ёстой;

(d) Багш нарт дэмжлэг үзүүлэх: Бүх багш, бусад ажилтан тэгш хамруулсан суралцах орчныг бүрдүүлэхэд хэрэгтэй суурь үнэт зүйлс, цогц чадамжийг олгох боловсрол, сургалтад хамрагдсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй багш нар мөн энэхүү тэгш хамруулсан суралцах орчны нэг хэсэг байх ёстой. Тэгш хамруулах соёл нь хамтран ажиллах, харилцах, асуудал шийдэх зэргээр ажиллах нөхцөл бүрдсэн хүртээмжтэй, дэмжлэг бүхий орчноор хангадаг;

(e) Ялгаатай байдлыг үнэлж хүндэтгэх: Суралцаж байгаа хамт олны гишүүн бүрийг хөгжлийн бэрхшээл, арьс үндэс, өнгө, хүйс, хэл, угсаатны соёл, шашин, улс төрийн болон бусад байр суурь, үндэсний, угсаатны, уугуул байдал эсвэл нийгмийн гарал, өмч, төрсөн байдал, нас, бусад нөхцөлөөс үүдэлтэй ялгаатай байдлыг ойлгон хүлээн авч, эн тэнцүү үзэж хүндэтгэх ёстой. Бүх суралцагч өөрсдийг нь үнэлж, хүндэтгэж, татан оролцуулж, сонсож байгааг мэдрэх ёстой. Тухайн газарт дарамт хүчирхийлэл, үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй арга хэмжээг авсан байвал зохино. Тэгш хамруулах нь суралцагч хувь хүн нэг бүрд чиглэсэн хандлага баримтлахыг хэлдэг;

(f) Суралцах үйлийг дэмжсэн ээлтэй орчин: Тэгш хамруулсан суралцах орчин нь хүн бүр өөрийгөө аюулгүй, дэмжлэгтэй, урамшуулж байгааг мэдрч, өөрийгөө илэрхийлж чаддаг хүртээмжтэй орчин байх бөгөөд сургуулийн эерэг хамт олныг бий болгоход суралцагчдаа онцгойлон анхаарч оролцуулдаг. Үе тэнгийнхэн хэсэг бүлгээрээ суралцах, эерэг харилцаа тогтоох, нөхөрлөх, нэг нэгнээ ойлгож хүлээж авах нь илүү байдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй;

(g) Үр дүнтэй шилжилт өөрчлөлт: Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид суралцаж байгаа сургуулиасаа мэргэжлийн боловсрол, дээд боловсрол эзэмшихээр, эцэст нь ажлын байранд шилжих явдлыг үр дүнтэй болгох үүднээс тодорхой дэмжлэг байх хэрэгтэй болдог. Суралцагчдын чадавх, өөртөө итгэх итгэлийг хөгжүүлж, тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангаж, тэднийг үнэлэх, шалгах дүрэм журамд адил тэгш хандаж, харилцаж, тэдний хүрсэн чадвар чадамж, амжилтыг бусадтай адил тэгш үзэж батламжлах ёстой;

(h) Түншлэлийг хүлээн зөвшөөрөх: Багш нарын холбоо, сурагчдын холбоо, нэгдсэн холбоо, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага, сургуулийн зөвлөл, эцэг эх – багш нарын холбоо, сургуулийг дэмждэг бусад албан болон албан бус шинжтэй бүлгийн зүгээс хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлэхийг хөхиүлэн дэмжвэл зохино. Эцэг эх, асран хамгаалагч, нутгийн олныг татан оролцуулах нь нөөц, давуу талаа дайчлан хувь нэмрээ оруулах боломж гэж тооцогддог. Суралцах орчин болон нутгийн

өргөн олны хоорондын харилцаа нь тэгш хамруулсан нийгмийг бий болгоход хүргэх зам гэж хүлээн зөвшөөрөх ёстой;

(i) Хяналт-шинжилгээ: Тасралтгүй үргэлжлэх үйл явцын хувиар тэгш хамран сургах боловсролыг тусгаарлаж эсвэл нэгтгэн сургахад албан болон албан бус байдлаар хүргэхгүй байх үүднээс байнга хяналт-шинжилгээ хийж байх ёстой. Конвенцын 33 дугаар зүйлийн дагуу хяналт-шинжилгээ хийхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг, тэр дундаа хүүхэд, маш ихээр дэмжлэг шаардлагатай хүмүүсийг тэдний төлөөллийн байгууллагаар дамжуулан оролцуулах ба шаардлагатай үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх эсвэл асран хамгаалагчийг оролцуулна. Хөгжлийн бэрхшээл ба тэгш хамруулсан талаарх шалгуур үзүүлэлтийг Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөртэй нийцүүлэн боловсруулж, ашиглах ёстой.

13.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын (НҮББШУСБ) Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай конвенцтой нийцүүлэн, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 24(1) дүгээр зүйлийг мөрдөхийн тулд Оролцогч улсууд ямарваа нэгэн ялгаварлан гадуурхалтгүйгээр тэгш боломжоор хангасан нөхцөлийн үндсэн дээр сурч боловсрох эрхийг баталгаажуулах ёстой. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлийн үндсэн дээр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг хориглож, хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр аливаа ялгаварлан гадуурхалтаас адил тэгш, үр дүнтэй хамгаалуулахыг баталгаажуулах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хөгжлийн бэрхшээл, жендэр, шашин, хууль зүйн статус, угсаа гарвал, нас, бэлгийн чиг баримжаа, хэлнээс шалтгаалан харилцан давхар нөхцөлдсөн ялгаварлан гадуурхалтад өртөх боломжтой. Мөн эцэг эх, ах/эгч, дүү, хамаатан садны хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотойн улмаас ялгаварлан гадуурхалтад өртөж болно. Боловсролын байгууллага болон нутгийн олны доторх хууль зүйн, бие махбодын, харилцаа холбооны, хэлний, нийгмийн, санхүүгийн, хандлагын хувьд учрах саад тотгорыг тодорхойлох, арилгах зэргээр ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг устгахад чиглэсэн арга хэмжээ авбал зохино. Ялгаварлан гадуурхалтгүй байх эрхэд тусгаарлуулахгүй байх эрх, тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангагдах эрх багтах төдийгүй хүртээмжтэй суралцах орчин, тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангах үүрэг хүлээсэн нөхцөл багтсан гэдгийг ойлгох ёстой.

14.Зэвсэгт мөргөлдөөн, онцгой байдлын нөхцөл, байгалийн гамшиг учирсан тохиолдолд тэгш хамруулах боловсрол олгох эрхэд үлэмж хэмжээгээр нөлөөлдөг. Оролцогч улсууд сургуулийн аюулгүй байдал, хамгаалалтыг цогц байдлаар хангасан, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад мэдрэмжтэй гамшигийн эрсдэлийг бууруулах тэгш хамруулсан стратегийг баталбал зохино. Дээрх тохиолдолд байгуулсан түр хугацааны суралцах орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг тэгш байдлын үүднээс бусадтай адил баталгаажуулах ёстой. Үүнд сонсголгүй суралцагчдад зориулсан хүртээмжтэй сургалтын материал, сургуулийн

байр, байгууламж, орон нутгийн дохионы хэл дээр зөвлөх үйлчилгээ, сургалт авах боломжийг ч багтаана. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 11 дүгээр зүйлд нийцүүлэн дээрх газарт бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл асар их байдгийг анхаарч, хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдэд аюулгүй, хүртээмжтэй суралцах орчныг баталгаажуулах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг онцгой байдлын үед нүүлгэн шилжүүлэхдээ боломжгүй гэсэн үндэслэлээр боловсролд хамруулахгүй байх ёсгүй бөгөөд тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангах ёстой.

15.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 24.1 дүгээр зүйлийн (а) хэсгийг биелүүлэхийн тулд, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрх, Хүүхдийн эрхийн тухай конвенцтой уялдан боловсрол хүний бүх талын хөгжлийг хангаж, өөрийн эрхэм чанар, үнэ цэнийг ухамсарлахад чиглэгдэж, хүний эрх, хүний ялгаатай байдлыг хүндэтгэх байдлыг бэхжүүлэхэд чиглэх ёстой. Оролцогч улсууд боловсролыг Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын зорилго, зорилттой нийцэж байгааг баталгаажуулж, Бүх нийтэд боловсрол олгох тухай дэлхийн тунхаглал (1 дүгээр зүйл), Хүүхдийн эрхийн тухай конвенц (29.1 дүгээр зүйл), Венийн тунхаглал болон Үйл ажиллагааны хөтөлбөр (I хэсэг, 33 дугаар догол мөр, II хэсэг, 80 дугаар догол мөр), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн боловсролын төлөөх арван жилийн Үйл ажиллагааны төлөвлөгөөний (2 дахь догол мөр) үзэл санаагаар тайлбарлах ёстой. Эдгээр баримт бичигт жендэрийн тэгш байдал, хүрээлэн буй орчныг хүндэтгэхтэй холбоотой нэмэлт заалтууд бий.⁵ Сурч боловсрох эрхийг баталгаажуулах нь хүртээмжийн зэрэгцээ агуулгатай холбогдох ба харилцан ойлголцох, хүлцэн тэвчих зэрэг өргөн хүрээтэй үнэт зүйлсийг хамгаалан дэмжихэд хүчин чармайлт гаргавал зохино.⁶ Тэгш хамруулах боловсрол нь хүн бүрийг харилцан хүндлэх, үнэ цэнэтэй гэж үзэх явдлыг хөхиүлэн дэмжиж, мөн суралцахад хандах хандлага-арга зүй, боловсролын байгууллагын соёл, сургалтын хөтөлбөрт ялгаатай байдлын үнэт зүйлийг тусгасан сургалтын орчныг бий болгохоор зорих ёстой.

16.Конвенцын 24.1 дүгээр зүйлийн (b) хэсгийг хэрэгжүүлэхийн тулд, боловсрол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүний хувийн зан чанар, авьяас, бүтээлч байдлын хамт тэдний оюуны, бие махбодын, харилцааны ур чадварыг бүрэн дүүрэн хөгжүүлэхэд чиглэх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсрол нь ихэнх тохиолдолд тэдний чадварын алдагдалд хандсан, тэдний бодит эсвэл байж болох согогт төвлөрсөн, мөн тэдний чадамжийг урьдчилан тодорхойлсон сөрөг төсөөллөөрөө боломжийг нь хязгаарлахад чиглэсэн байдаг. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүн нэг бүрийн онцлог давуу тал, авьяаст тулгуурлан өсч хөгжих боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх ёстой.

⁵ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо, Ерөнхий зөвлөмж No.13.

⁶ Хүүхдийн эрхийн хороо, Боловсролын зорилгын тухай Ерөнхий зөвлөмж No.1.

17.Конвенцын 24.1 дүгээр зүйлийн (с) хэсгийг биелүүлэхийн тулд, боловсролын зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс чөлөөт нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох боломжийг хангахад чиглэх ёстой. Хүүхдийн эрхийн тухай конвенцын 23.3 дугаар зүйлийг дахин сануулж, Хорооны зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгэмд дээд зэргээр нэгтгэх, хувь хүний хөгжлийн хамгийн дээд түвшинд хүрэхэд ээлтэй нөхцөлийг бүрдүүлсэн боловсрол хүртээмжтэй байхад дэмжлэг үзүүлэх ёстойг чухалчилсан билээ. Оролцогч улсууд хувь хүнд үзүүлэх дэмжлэг, тохируулгат хэрэглэгдэхүүнийг эн тэргүүнд чухалчлах, боловсролыг заавал эзэмших бүх түвшинд үнэ төлбөргүй олгохыг хүлээн зөвшөөрөх ёстой.

18.Конвенцын 24.2 дугаар зүйлийн (а) хэсгийг хэрэгжүүлэхийн тулд, нийтэд зориулсан боловсролын тогтолцооноос хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гадуурхахыг, тэр дундаа тэдний бэрхшээлд нь тулгуурлан эсвэл бэрхшээлийн зэргээс нь хамаарч тэднийг тэгш хамруулахыг хязгаарлах, тодруулбал хувь хүний чадамжийн хэмжээнээс хамаарч тэгш хамруулах нөхцөлөө заах буюу тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангах үүргээс зайлсхийх зорилгоор, үндэслэлгүй эсвэл зохицоогүй шалтаг гаргах зэргийг аливаа хууль тогтоомж эсвэл бусад зохицуулалтаар хориглох шаардлагатай.

Нийтэд зориулсан боловсрол гэдэгт аливаа ердийн суралцах орчин, боловсролын газар багтана. Шууд гадуурхах гэдэг нь тодорхой суралцагчдыг “сурч чадахгүй” хэмээн ангилж, боловсрол эзэмших эрхгүй гэж үзэхийг ойлгоно. Шууд бусаар гадуурхахад тухайн сургуульд элсэн орохын тулд тохируулгат хэрэглэгдэхүүн, дэмжлэггүйгээр нийтийн шалгалтад тэнцсэн байх шаардлага тавихыг мөн багтаана.

19.Конвенцын 4.1 дүгээр зүйлийн (b) хэсгийг хэрэгжүүлэхийн тулд, Оролцогч улсууд, 24 дүгээр зүйлийн зөрчихөд хүргэж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхаж байгаа одоогийн хууль, зохицуулалт, уламжлал, өдөр тутамд хийж хэвшсэн үйл ажиллагааг өөрчлөх эсвэл арилгахын тулд хууль тогтоомж гаргах зэрэг бүхий л зохистой арга хэмжээг авах ёстой. Шаардлагатай тохиолдолд ялгаварлан гадуурхсан хууль, зохицуулалт, уламжлал, өдөр тутамд хийж хэвшсэн үйл ажиллагааг дэс дараатай, заасан хугацааны дотор халах эсвэл өөрчлөх ёстой.

20.Конвенцын 24.2 дугаар зүйлийн (b) хэсгийг хэрэгжүүлэхийн тулд, өөрийн амьдарч байгаа орон нутгийн бусад хүний нэгэн адил хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэгш хамруулсан, чанартай, үнэ төлбөргүй бага ба дунд боловсрол эзэмших, дээрх хоёр түвшний хооронд түвэггүй шилжих боломжтой байх ёстой. Хороо Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны зөвлөмжид дурдсанаар дээрх үүргээ биелүүлэхийн тулд хүрэлцээтэй, хүртээмжтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, уян хатан байх

гэсэн хоорондоо харилцан холбоотой дөрвөн шинжийг боловсролын тогтолцоондоо агуулсан байх ёстойг дурдаж байна.⁷

Хүрэлцээтэй байх

21.Төрийн болон төрийн бус өмчийн боловсролын байгууллага, хөтөлбөр нь тооны болон чанарын хувьд хангалттай хүрэлцээтэй байх ёстой. Оролцогч улсууд орон нутгийн бүхий л түвшинд боловсролын байгууллагын суудлын тоо хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад хангалттай байхыг баталгаажуулах ёстой.

Хүртээмжтэй байх

22.Конвенцын 9 дүгээр зүйл болон Хорооны Хүртээмжийн тухай Ерөнхий зөвлөмж No.2-той нийцүүлэн, боловсролын байгууллага, хөтөлбөр нь ямар ч ялгаварлан гадуурхалтгүйгээр хүн бүрд хүртээмжтэй байх ёстой. Барилга байшин, мэдээлэл, харилцаа холбооны хэрэглэгдэхүүн (орчны буюу давтамжит авианы туслах тогтолцоо г.м.), сургалтын хөтөлбөр, сургалтын материал, заах арга зүй, үнэлгээ, хэл ярианы болон бусад дэмжих үйлчилгээ гээд боловсролын тогтолцоо бүхэлдээ хүртээмжтэй байх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын [суралцаж буй] орчин нь тэдний боловсрол эзэмших бүхий л явцад тэгш хамруулахыг хөхүүлэн дэмжсэн бөгөөд тэдний тэгш байдлыг баталгаажуулах байдлаар зохион байгуулагдсан байх ёстой.⁸ Жишээлбэл, сургуулийн автобус, усан хангамж, ариун цэврийн байгууламж (ариун цэвэр сахих, бие засах байгууламжийг оролцуулан), хоолны газар, тоглох болон чөлөөт цагаа өнгөрүүлэх газар нь тэгш хамруулсан, хүртээмжтэй, аюулгүй байвал зохино. Оролцогч улсууд түгээмэл загварыг түргэн шуурхай нэвтрүүлэх үүрэг хүлээнэ. Оролцогч улсууд хүртээмжгүй дэд бүтэц бүхий сургуулийн барилга, байгууламжийг цаашид барихыг зогсоох, улмаар хориг тавьж, одоогийн боловсролын бүх орчноо хүртээмжтэй болгон шинэчлэхийн тулд тусгайлан хугацаа зааж, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх үр дүнтэй механизмыг бий болгох ёстой. Оролцогч улсууд тэрчлэн шаардлагатай үед боловсролын байгууллагыг тохируулгат орчин, хэрэглэгдэхүүнээр хангах үүргийг хүлээх ёстой. Түгээмэл загварын хандлагыг хэрэгжүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад шаардлагатай туслах хэрэгслүүд төдийгүй аппликэйшн, компьютерын хэрэглээний программ хангамжаар хангах шаардлагатай. Хүртээмжтэй байдал гэдэг нь үргэлж хувьсан өөрчлөгдөж шинэчлэгдэж байдаг ойлголт бөгөөд хүртээмжтэй байдлыг бий болгохдоо холбогдох бодлого журмын нэмэлт өөрчлөлт болон техникийн шинжтэй өөрчлөлтийг тогтмол хугацаанд хийж байхыг шаарддаг. Оролцогч улсууд нь бүх суралцагч, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хувьд суралцах явцыг улам хүртээмжтэй болгохын тулд инновац болон шинэ технологийг хурдацтай хөгжлийг ашиглах ёстой.

⁷ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо, Ерөнхий зөвлөмж No.13.

⁸ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо, Ерөнхий зөвлөмж No.2.

23.Хороо нь дохионы хэл зэрэг хүртээмжтэй хэлбэр, хэлээр сурах бичиг, сургалтын материал маш дутмаг байгааг цохон тэмдэглэж байна. Оролцогч улсууд нь бэхээр эсвэл Брайл үсгээр болон шинэлэг технологийг ашиглан дижитал хэлбэрээр сургалтын хэрэглэгдэхүүнийг цаг алдалгүй боловсруулан бэлэн болгоход шаардлагатай хөрөнгө нөөцийг зарцуулах ёстой. Мөн хэвлэмэл материалыг хүртээмжтэй хэлбэр, хэл рүү хөрвүүлэхэд ашиглах стандарт, журмыг боловсруулах болон хүртээмжтэй байдлыг боловсролтой холбоотой худалдан авах ажиллагааны гол анхаарах асуудал болгох шаардлагатай. Хороо нь оролцогч улсуудыг Хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох тухай Марракешийн гэрээг даруй соёрхон батлах, хэрэгжүүлэхийг уриалж байна.

24.Хүртээмжтэй байдал нь бүх шат түвшний боловсролын үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хувьд үнэ төлбөрийн хувьд боломжтой байхыг шаарддаг. Тохируулгат орчин нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдаас нэмэлт зардал гаргуулах ёсгүй. Заавал эзэмших, чанартай, үнэ төлбөргүй, хүртээмжтэй бага боловсролыг олгох нь нэн даруй биелүүлэх үүрэг билээ. 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөртэй нийцүүлэн оролцогч улсууд бүх хүүхэд ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн үнэ төлбөргүй, тэгш боломжоор хангасан, чанартай дунд боловсрол эзэмших; хөгжлийн бэрхшээлтэй бүх эрэгтэй, эмэгтэй иргэний төлбөрийн хувьд боломжийн бөгөөд чанартай техникийн, мэргэжлийн болон их дээд сургуульд суралцах болон насан туршдаа суралцах тэгш боломжийг баталгаажуулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх ёстой. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төрийн болон төрийн бус өмчийн аль ч боловсролын байгууллагуудад бусдын адил боловсрол эзэмших хүртээмжийг баталгаажуулах ёстой.

Хүлээн зөвшөөрөгдсөн байх

25.Хүлээн зөвшөөрөгдсөн байх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шаардлага, соёл, үзэл бодол, хэлийг бүрэн дүүрэн анхаарч, хүндэтгэх замаар боловсролтой холбоотой бүх байгууламж, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөн зохион байгуулж, хэрэгжүүлэх үүрэг юм. Боловсрол олгох хэлбэр, мөн чанар нь бүх хүнд хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой. Оролцогч улсууд хүн бүрд сайн чанартай боловсрол олгох үйл ажиллагааг дэмжсэн арга хэмжээг батлах ёстой.⁹ Тэгш хамруулах, чанартай байх нь харилцан хамааралтай: тэгш хамруулах хандлага баримталснаар боловсролын чанарт үлэмж хувь нэмэр оруулж болно.

Уян хатан байх

26.Хороо нь оролцогч улсуудыг бүх суралцагчийн харилцан адилгүй эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хичээлээ заах болон суралцах орчинг өөрсдөө тохируулж болох зохион байгуулалтын бүтэц бий болгох боломжийг багш болон сургуулийн бусад ажилтнуудад олгосон багц

⁹ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо, Ерөнхий зөвлөмж No. 13.

зарчмаас бүрдсэн суралцахуйн түгээмэл загварын хандлагыг баталж хэрэгжүүлэхийг уриалж байна. Энэ нь суралцагч бүр суралцах өөрийн онцлог хэв маягтай гэдгийг хүлээн зөвшөөрч, суралцах уян хатан арга зам боловсруулах; ангид оролцоог хангахуйц орчин бий болгох; суралцагчдаас өндөр хүлээлттэй байхын зэрэгцээ олон арга замаар хүлээлтээ биелүүлэх боломжийг олгох; багш нар өөрийн зааж байгаа хичээлээ эргэцүүлж, өөрчилж зааж чаддаг болгон эрх мэдэлжүүлэх; хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг бүх хүний боловсролын үр дүнд анхаарах зэргийг багтаадаг. Сургалтын хөтөлбөрийг суралцагч нэг бүрийн шаардлагыг хангах болон түүнд тохирон өөрчлөгдөх боломжтой бөгөөд сургалтын зохих хариу үйлчилгээг үзүүлэх боломжтой байхаар боловсруулах хэрэгтэй. Стандартчилсан үнэлгээний оронд үнэлгээний уян хатан бөгөөд олон хэлбэрийг ашиглах ба суралцахуйн хувилбарт арга замыг хангах өргөн хүрээний зорилгод чиглэсэн хувь хүний ахицыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

27. Конвенцын 24.2 дугаар зүйлийн (b) хэсэгт заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрийн амьдран суугаа газартаа бага, дунд сургуульд элсэх боломжтой байх ёстой. Суралцагчдыг гэрээс нь холдуулж болохгүй. Боловсролын орчин нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүрч очиход аюулгүй биет хүртээмжтэй байхын зэрэгцээ аюулгүй, найдвартай тээврийн хэрэгсэл, мэдээлэл, харилцаа холбооны технологиор дамжуулан холбогдох хүртээмжтэй байх ёстой. Гэхдээ оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын шууд оролцоо, боловсрол сургалтын орчинд багштай харилцах, үлгэр загвар болох хүмүүстэй нүүр тулах харилцааг орлуулах байдлаар технологид хэт найдахаас зайлсхийх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын бусад суралцагчидтай болон ах/эгч, дүү нартайгаа идэвхтэй харилцах, оролцох нь тэгш хамрагдан сурч боловсрох эрхийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

28. Конвенцын 24.2 дугаар зүйлийн (c) хэсэгт заасны дагуу оролцогч улсууд суралцагч бүр бусдын нэгэн адил боловсрол эзэмших боломжийг олгохын тулд тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангах ёстой. “Тохируулгат байдал” гэдгийг тохируулгат хэрэглэгдэхүүний учир холбогдол, үр дүнтэй байдлын дүн шинжилгээ бүхий хам нөхцөлд нь туршиж үзсэн ажлын үр дүн болон ялгаварлан гадуурхалтын эсрэг тэмцлээс хүлээгдэж буй зорилго гэж ойлгоно. Тохируулгат хэрэглэгдэхүүн хийх нь дааж давшгүй зардалтай эсэхийг нөөцийн хүрэлцээтэй байдал, санхүүгийн үр дагаврыг нь үнэлж байж хүлээн зөвшөөрч болно. Тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангах үүргийг тус хэрэглэгдэхүүнтэй болох хүсэлт гаргасан үеэс эхлэн биелүүлнэ.¹⁰ Тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангах бодлогыг үндэсний, орон нутгийн боловсролын байгууллагын түвшинд төдийгүй боловсролын бүх шат түвшинд батлах ёстой. Тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангахдаа одоо байгаа нөөцийг дээд хэмжээнд ашиглах, шинээр хөрөнгө нөөц бий болгох замаар тэгш хамран сургах боловсролын тогтолцоог

¹⁰ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо, Ерөнхий зөвлөмж No. 2.

хөгжүүлэх нийтлэг үүргээ гүйцэтгэж байгаа хүрээнд авч үзнэ. Тэгш хамран сургах боловсролын чиглэлд ахиц дэвшил гаргаагүйгээ нөөц дутмаг, санхүүгийн хямралаас үүдэлтэй гэж зөвтгөх нь 24 дүгээр зүйлийг зөрчиж байна гэж үзнэ.

29.Хороо нийтлэг хүртээмжийг хангах болон тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангах үүргийн хоорондын ялгааг дахин сануулж байна.¹¹ Хүртээмжтэй байх нь хүн амын тодорхой бүлэгт ач тустай байх ба аажмаар хэрэгжүүлэх цогц стандартуудад тулгуурласан байдаг. Тохируулгат хэрэглэгдэхүүн хийж хүчрэхгүй эсвэл хэрээс хэтэрсэн зардалтай гэдэг нь хүртээмжийг хангаж чадаагүйгээ хамгаалах үндэслэл биш. Тохируулгат хэрэглэгдэхүүн нь хувь хүнд зориулагдах ба хүртээмжийг хангах үүрэгт нэмэлт шинжтэй ойлголт юм. Оролцогч улсын зүгээс хүртээмжийг хангах үүргээ гүйцэтгэсэн байсан ч хувь хүн тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангахыг хуулийн дагуу шаардаж болно.

30.Юуг хүчирч хийж чадах вэ гэдгийг тодорхойлох нь тухайн нөхцөл байдлаас хамаарна. Тохиргоо хүрэлцээтэй байх нь боловсролын тогтолцооны хэмжээнд бэлэн байгаа нөөцийн тухай асуудал ба тухайн академик байгууллагад байхгүй тохиолдолд тогтолцоон дотроо нөөцөө шилжүүлэх боломжтой байхыг ойлгоно. Адил хөгжлийн бэрхшээлтэй ч суралцагчид харилцан адилгүй тохиргоо шаарддаг тул тохируулгат хэрэглэгдэхүүнд “нэг хэмжээ бүгдэд тохирно” гэсэн томьёо үйлчлэхгүй. Тохируулга гэдэгт ангийн байрлалыг өөрчлөх; анги дотроо өөр өөр хэлбэрээр харилцаа холбоо тогтоох боломжийг бий болгох; томруулан хэвлэх, материал, сэдвийг тэмдэглэгээ ашиглан илэрхийлэх эсвэл гарын авлагыг хувилбарт хэлбэр, хэмжээгээр бэлтгэж өгөх; суралцагчдад тэмдэглэл хөтлөгч эсвэл хэлмэрч гаргаж өгөх, суралцах, үнэлэх тохиолдолд туслах технологи ашиглахыг суралцагчдад зөвшөөрөх зэрэг багтана. Материаллаг бус тохиргоонд суралцагчид даалгавраа гүйцэтгэхэд илүү их цаг өгөх, гадны дуу чимээг бууруулах (мэдрэх ачаалал их учраас хэт мэдрэмтгий байх), үнэлгээний хувилбарт арга ашиглах, сургалтын хөтөлбөрийн зарим бүрэлдэхүүн хэсгийг орлуулах зэрэг багтана. Боловсролын албан тушаалтан, үйлчилгээ үзүүлэгч, академик байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч, шаардлагатай тохиолдолд суралцагчдын нас, чадавхаас хамааран тэдний эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн бусад гишүүдийн хэлэлцэж ярилцсаны үндсэн дээр тавигдах шаардлагын дагуу, суралцагчийн хүсэл, онцлог, сонголттой нийцсэн тохируулгыг үйлчилгээ үзүүлэгч хийж хэрэгжүүлнэ. Тохируулгат хэрэглэгдэхүүнийг хийхдээ согогийн талаарх эмнэлгийн оношноос илүүтэйгээр боловсрол эзэмшихэд тулгарч байгаа нийгмийн саадыг үнэлсэн үнэлгээнд тулгуурлана.

31.Тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангаагүй тохиолдолд ялгаварлан гадуурхалтад хүргэх төдийгүй тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангах үүрэг нь дэвшилтэт байдлаар хэрэгжүүлэх биш, нэн даруй гүйцэтгэх шинжтэй байна. Оролцогч улсууд хэрэглэгдэхүүний зохистой, үр

¹¹ Мөн тэнд.

нөлөөтэй байдлыг хянах хараат бус тогтолцоог байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч, шаардлагатай тохиолдолд тэдний эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн бусад гишүүд зохистой байдлаар хангаагүй эсвэл ялгаварлан гадуурхалтад өртсөн гэж гомдол гаргавал асуудлаа шийдвэрлүүлэх аюулгүй, зохистой, хүртээмжтэй механизмаар хангах ёстой. Асуудлаа шийдвэрлүүлэх явцад ялгаварлан гадуурхагдсан нэгнийг нэмж хохирохоос хамгаалах арга хэмжээг зайлшгүй авах ёстой.

32.Конвенцын 24.2 дугаар зүйлийн (d) хэсгийг хэрэгжүүлэхийн тулд, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч үр дүнтэй боловсрол эзэмшихэд туслах, бусдын нэгэн адил өөрийн потенциалдаа тултал хөгжихийн тулд дэмжлэг авах эрхтэй. Боловсролын тогтолцоон дахь үйлчилгээ, байгууламжийг ерөнхий хүрэлцээтэй байдлын үүднээс авч үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид өөрийн чадамжаа хамгийн дээд хэмжээнд хүрэх нөхцөлийг хангах, жишээлбэл хангалттай сайн бэлтгэгдсэн, дэмжлэг бүхий багш болон бусад ажилтан, сургуулийн зөвлөх үйлчилгээний ажилтан, сэтгэл зүйч, холбогдох эрүүл мэндийн болон нийгмийн үйлчилгээний мэргэжилтэнтэй байх, тэтгэлэг, санхүүгийн эх үүсвэр хүртээмжтэй байх зэргийг дэмжлэг гэж ойлгоно.

33.Конвенцын 24.2 дугаар зүйлийн (e) хэсгийг биелүүлэхийн тулд, хангалттай хэмжээний, тасралтгүй үргэлжилсэн, хувь хүнд чиглэсэн дэмжлэгийг шууд үзүүлнэ. Хороо хувь суралцагч бүрд шаардлагатай туслах нэмэлт хэрэгсэл, хувилбарт/хүртээмжтэй хэлбэртэй сургалтын тусгай материал, харилцааны хэрэгсэл, өөр бусад хэв маяг, туслах хэрэгсэл, мэдээллийн болон туслах технологи зэрэг тохируулгат хэрэглэгдэхүүн, тусгай дэмжлэгийг багтаасан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулах хэрэгцээг онцлон анхааруулж байна. Дэмжлэг гэдэгт суралцагчийн шаардлагаас хамааран сурагчдын дунд эсвэл ганцаарчлан ажиллах, суралцах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой тусгайлан мэргэшсэн туслах ч мөн багтана. Сургалтын ганцаарчилсан төлөвлөгөө нь тусгаарласан орчноос ердийн сургалтын байгууллага руу, мөн боловсролын шат түвшний хооронд шилжих шилжилтийг тусгаж шийдвэрлэх ёстой. Дээрх төлөвлөгөөний үр нөлөөтэй байдлыг тухайн суралцагчийн шууд оролцоотойгоор тогтмол хянаж, үнэлнэ. Тус төлөвлөгөөнд тусгах заалтуудыг суралцагч, шаардлагатай тохиолдолд эцэг эх, асран хамгаалагч эсвэл бусад гуравдагч талуудтай хамтран тодорхойлох ёстой. Уг дэмжлэг нь хангалтгүй эсвэл байхгүй байвал суралцагч гомдол гаргах механизмд хандах боломжтой байх ёстой.

34.Аливаа дэмжих арга хэмжээг үзүүлэхдээ тэгш хамруулахын зорилготой уялдуулах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад ангид явагдах болон сургуулиас гадуур зохиогдох ажиллагаанд гадуурхагдахаас илүүтэй үе тэнгийнхэнтэйгээ хамт оролцох боломжийг нэмэгдүүлэхийн тулд дэмжих арга хэмжээг авна.

35.Цөөнгүй оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа аутизмын хүрээний эмгэгтэй, харилцаа, хэл ярианы согогтой, мөн мэдрэхүйн бэрхшээлтэй, хүмүүс боловсролд, өөрийн хамт олны дунд

оролцоход шаардлагатай 24.3 дугаар зүйлд заасан амьдрах ухаан, хэл ярианы, нийгмийн ур чадвар олж авах тохиромжтой нөхцөлийг хангаж чадахгүй байна:

(а) Хараагүй, сул хараатай суралцагчдад Брайл үсэг, хувилбарт бичиг үсэг, нэмэлт болон хувилбарт горим, харилцаа холбооны арга зам, хэлбэр, чиг баримжаа, хөдөлгөөний ур чадварт сурах боломжоор хангах ёстой. Суралцахад хялбар дөхөм болгох үүднээс тохиромжит технологи, хувилбарт харилцаа холбооны тогтолцоог ашиглах зорилгоор хийх хөрөнгө оруулалтыг дэмжих нь зүйтэй. Үе тэнгийн дэмжлэг, зөвлөн чиглүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийг дэмжинэ;

(b) Дүлий, сонсголын бэрхшээлтэй суралцагчдыг дохионы хэл сурах боломжоор хангаж, дүлий олон нийтийн хэлний амин чанарыг хүлээн зөвшөөрч, хөхиүлэн дэмжих арга хэмжээг авах ёстой. Хороо өөрийн хэлээр сурч боловсрох хүүхдийн эрхийг заасан Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай конвенцын заалтад оролцогч улсуудын анхаарлыг хандуулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 30.4 дүгээр зүйлийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын нэгэн адил дохионы хэл, дүлий хүмүүсийн соёл зэрэг өөрийн тусгай соёл, хэлний амин чанараа хүлээн зөвшөөрүүлэх, дэмжлэг авах эрхтэй байна. Үүний зэрэгцээ сонсголын бэрхшээлтэй суралцагчдын хувьд хэл, яриа заслын чанартай үйлчилгээ, сонсгол дэмжих технологи хүртээмжтэй байж, дэлгэцээр текст унших боломжтой байна;

(c) Хараагүй, дүлий, хараагүй-дүлий суралцагчдыг өөрсдөд нь хамгийн тохирох хэл, хувь хүнд зориулсан харилцаа холбооны горим, арга хэрэгсэл, ашиглан боловсрол эзэмшиж, хувь хүний, эрдэм оюуны болон нийгмийн хөгжлөө хамгийн дээд түвшинд хүргэх орчинг албан боловсролын хүрээнд болон гадна бүрдүүлэх ёстой. Хороо тэгш хамруулсан орчинг бий болгохын тулд Оролцогч улсуудаас урсгал нөөц, туслах технологи, орон зай, чиг баримжааны ур чадвар зэрэг шаардлагатай дэмжлэгээр хангахыг цохон тэмдэглэсэн байна;

(d) Харилцааны бэрхшээлтэй суралцагчид өөрсдийгөө илэрхийлэх, хувилбарт эсвэл нэмэлт харилцааны арга хэлбэрийг ашиглаж сурах боломжоор хангагдах ёстой. Дохионы хэл, ярианы хэрэгсэлтэй таблет, дуу хоолой гаргах харилцааны нэмэлт хэрэгсэл, харилцааны ном зэрэг нам эсвэл өндөр технологийн харилцаа холбооны туслах хэрэгслүүд үүнд багтана. Оролцогч улсууд суралцах явцыг хялбар дөхөм болгохын тулд тохиромжтой технологи, хувилбарт харилцааны систем хүртээмжтэй байх боломжийг нэмэгдүүлэхийн тулд мэргэжилтэн бэлтгэх, технологи, үйлчилгээг хөгжүүлэхэд хөрөнгө оруулах ёстой;

(e) Нийгмийн харилцааны хувьд бэрхшээлтэй суралцагчдад хосоор ажиллах, үе тэнгийнхэн харилцан дэмжих, багшдаа ойр суух, хэсэгчлэн төлөвлөсөн болон урьдчилан таамаглахуйц орчныг бий болгох зэргээр ангийн зохион байгуулалтыг өөрчлөх замаар дэмжлэг үзүүлэх ёстой;

(f) Оюуны бэрхшээлтэй суралцагчдыг бие даан амьдрах, ажил хийхэд бэлтгэх, шаардлагатай чадавхыг дээд хэмжээнд хүргэхэд чиглэсэн тодорхой, ажиглах/дүрслэн харуулсан бөгөөд хялбар уншигдах хичээлийн хэрэглэгдэхүүнээр хангаж, аюулгүй, нам гүм, хэсэгчлэн төлөвлөсөн сурах орчныг бүрдүүлэх ёстой. Оролцогч улсууд хувилбарт заах арга, үнэлгээний арга ашигладаг тэгш хамруулах, оролцоог бий болгох анги танхимуудад хөрөнгө оруулна.

36.Конвенцын 24.4 дүгээр зүйлийг биелүүлэхийн тулд, оролцогч улсууд тэгш хамран сургах боловсролын орчинд үр нөлөөтэй ажиллахуйц ур чадвартай, дохионы хэл ба/эсвэл Брайл үсгийн туршлагатай орон зай, чиг баримжааны ур чадвартай захиргааны ажилтан, багш, болон бусад ажилтныг ажилд авахын тулд зохих арга хэмжээг авах шаардлагатай. Зохистой тооны, туршлагатай, хичээл зүтгэлтэй сургуулийн ажилтан нь тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэх, тогтвортой хадгалах үндэс билээ. Мэдлэг ойлголт дутмаг, чадавх бүрдэхгүй байх нь тэгш хамруулахад учирдаг гол саадын нэг болсоор байна. Оролцогч улсууд бүх багш нарыг тэгш хамран сургах боловсролын талаар сургаж, тухайн сургалт нь хөгжлийн бэрхшээлийн тухай хүний эрхийн загварт суурилсан байх ёстой.

37.Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй багшийг ажилд авах, тасралтгүй сургаж боловсрол дээшлүүлэхийг дэмжиж, хөрөнгө оруулах ёстой. Үүнд өргөдөл гаргагчдад эрүүл мэндийн тодорхой шалгуурыг хангах, багшийн хувиар өөрөө оролцохдоо тохируулгат хэрэглэгдэхүүнтэй байхыг шаарддаг аливаа хууль тогтоомжийн эсвэл бодлогын саадыг арилгах хүртэл багтана. Тэдний оролцоо нь багшлах мэргэжил эзэмшихэд тэгш байхыг хөхиүлэн дэмжих, суралцах үйл явцад өөрсдийн өвөрмөц туршлага, ур чадвараа хуваалцах, саадыг арилгахад хувь нэмэр оруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үлгэр дууриал болох болно.

38.Конвенцын 24.5 дугаар зүйлийг мөрдүүлэхийн тулд, оролцогч улсууд ялгаварлан гадуурхалтгүйгээр бусдын нэгэн адил хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс дээд боловсрол, мэргэжлийн сургалт, насанд хүрэгчдийн боловсрол, насан туршдаа суралцах боломжийг баталгаажуулах ёстой. Эдгээр түвшний боловсрол дахь хандлагын, орчны, хэлний, харилцаа холбооны, санхүүгийн, хууль эрх зүйн болон бусад саадыг тодорхойлон тогтоож, тэгш боломжийг хангах үүднээс арилгавал зохино. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхалтад өртүүлэхгүйн тулд тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангах ёстой. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад таатай нөхцөлийг бүрдүүлэх үүднээс дээд боловсролын түвшинд дэмжих арга хэмжээг авахаар зорих ёстой.

III. Оролцогч улсуудын хүлээх хариуцлага

39.Оролцогч улсууд тэгш хамран сургах боловсролын амин чухал бүрэлдэхүүн хэсэг болсон хүрэлцээтэй, хүртээмжтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, уян хатан байх шинж чанарыг хүндэтгэх, хамгаалах,

хангах ёстой. Хүндэтгэх үүрэг нь хууль тогтоомжоор хөгжлийн бэрхшээлтэй зарим хүүхдийг гадуурхах, эсвэл хүртээмжгүй байдал, тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангахгүй байх зэрэг тухайн эрхийг эдлэхэд саад болох арга хэмжээ авахаас зайлсхийхийг шаарддаг. Хамгаалах үүрэг нь жишээлбэл хөгжлийн бэрхшээлтэй охидыг эцэг эх нь сургуульд явуулахаас татгалзах, эсвэл хувийн байгууллагын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бэрхшээлээс хамаарч элсэн сургахаас татгалзах зэргээр тухайн эрхийг эдлэхэд гуравдагч этгээд хөндлөнгөөс оролцох үйлдлээс урьдчилан сэргийлэхийг шаарддаг. Хангах үүрэг нь жишээлбэл боловсролыг байгууллага нь хүртээмжтэй байх, боловсролын тогтолцоо нь өөрт байгаа нөөц, үзүүлж байгаа үйлчилгээгээ тохируулан өөрчлөх зэргээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сурч боловсрох эрхээ эдлэхэд дэмжих үйлдэл хийхийг шаарддаг.

40. Конвенцын 4.2 дугаар зүйл нь оролцогч улсууд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг бүрэн хэрэгжүүлэхийг эрчимтэйгээр хангахын тулд өөрийн боломжит нөөцийг дээд хэмжээнд ашиглах, шаардлагатай тохиолдолд олон улсын хамтын ажиллагааны хүрээнд арга хэмжээ авахыг шаарддаг. Эрчимтэйгээр хангах гэдэгт оролцогч улсууд аль болох түргэн шуурхай, үр дүнтэй 24 дүгээр зүйлийг бүрэн хэрэгжүүлэх тусгай, тасралтгүй үргэлжлэх үүрэг хүлээдэг гэж ойлгоно.¹² Энэ нь нийтэд зориулсан боловсролын тогтолцоо болон тусгай/тусгаарласан боловсролын тогтолцоо гэсэн боловсролын хоёр тогтолцоо зэрэгцэн орших ёсгүй гэсэн үг. Эрчимтэйгээр хангах гэдгийг тухайн эрхийг бүрэн хэрэгжүүлэх оролцогч улсуудын үүргийг нарийвчлан тогтоохын тулд конвенцын үндсэн зорилготой холбож харах ёстой. Үүнтэй адилаар оролцогч улсууд тэгш хамран сургах боловсролыг хөгжүүлэхэд төсвийн тодорхой хэсгийг шилжүүлэн зарцуулах зэргээр боловсролд зориулсан төсвийн хуваарилалтаа эргэн харах хэрэгтэй болно. Ямар нэгэн байдлаар шууд дордуулсан арга хэмжээг боловсролын аливаа түвшин дэх хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид руу зохисгүй хэмжээгээр чиглүүлэн авч болохгүй.¹³ Хямралын үед зайлшгүй шаардлагын үүднээс зохистой байдлаар хязгаарласан арга хэмжээ авч болох ч ялгаварлан гадуурхсан байж болохгүй бөгөөд тэгш бус байдлыг багасгахад бүх боломжит арга хэмжээгээ авах ёстой.¹⁴

41. Дэвшил Эрчимтэйгээр хангахдаа тэр даруй шууд үүргээ биелүүлэх боломжгүйг хүлээн зөвшөөрөх ёстой. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны Оролцогч улсуудын үүргийн мөн чанарын тухай 1990 оны Ерөнхий зөвлөмж No.3-т оролцогч улсууд хамгийн наад зах нь сурч боловсрох эрхийн агуулга бүрийн хүрсэн байх жишиг түвшинг

¹² Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо, Оролцогч улсуудын үүргийн мөн чанарын тухай 1990 оны Ерөнхий зөвлөмж No. 3. 9 дэх догол мөрийг үзнэ үү.

¹³ Мөн тэнд.

¹⁴ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын оролцогч улсууд хандсан Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны даргын 2012 оны 5 дугаар сарын 16-ны өдөр бичсэн захиа.

хангахуйц хэмжээнд үүрэг хүлээдэг болохыг дурдсан юм.¹⁵ Иймээс оролцогч улсууд дараах тулгуур эрхийг даруй хангах ёстой:

(а) Боловсролын бүхий л хүрээнд ялгаварлан гадуурхалтын олон улсад хориглосон бүх нөхцөл байдлыг хамруулан ялгаварлан гадуурхахгүй байх. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан боловсролоос гадуурхахгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүн бүрийн үр дүнтэй оролцоо, тэгш байдлыг хангахад тулгардаг бүтцийн шинжтэй сул талыг арилгах ёстой. Оролцогч улсууд тэгш хамрагдан сурч боловсрох эрхийг дордуулж байгаа ялгаварлан гадуурхсан хууль зүйн, захиргааны, бусад бүх хэлбэрийг арилгах алхмыг яаралтай хийх ёстой. Дэмжих арга хэмжээг батлахдаа боловсролын талаар ялгаварлан гадуурхахгүй байх эрхийг зөрчиж, харилцан адилгүй бүлэгт зориулсан тэгш бус эсвэл тусдаа стандарт тогтооход хүргэж болохгүй;

(b) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг боловсролоос гадуурхахгүй байхыг тохируулгат хэрэглэгдэхүүн баталгаажуулна. Тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангаж чадахгүй байх нь хөгжлийн бэрхшээлийн үндсэн дээр ялгаварлан гадуурхахад хүргэдэг;

(c) Заавал эзэмших, үнэ төлбөргүй суурь боловсрол хүн бүрд хүрэлцээтэй байх ёстой. Оролцогч улсууд тэгш хамруулах үзэл санаанд тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй бүх хүүхэд, залуусын эрхийг баталгаажуулах зохистой бүхий л арга хэмжээг авах ёстой. Хороо Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх хөтөлбөртэй нийцүүлэн бүх хүүхэд, залуучууд чанартай боловсрол эзэмших, дүүргэх, хамгийн багадаа 12 жилийн үнэ төлбөргүй, улсын төсвөөс санхүүжсэн, тэгш хамруулсан, тэгш боломжоор хангасан чанартай, бага, дунд боловсрол, түүнээс наад зах нь 9 жилийн боловсролыг заавал эзэмшүүлэх, мөн сургуулийн гадна байгаа хүүхэд, залуучуудад төрөл бүрийн арга замаар чанартай боловсрол олгохыг оролцогч улсуудаас шаардаж байна.

42.Оролцогч улсууд тэгш хамруулах, боломжийг тэгш байдлаар хангах үндсэн дээр бүх шат түвшний боловсролыг суралцагч нэг бүрд олгоход чиглэсэн үндэсний боловсролын стратеги баталж, хэрэгжүүлэх ёстой. 24.1 дүгээр зүйлд заасан боловсролын зорилт нь оролцогч улсуудад адил түвшний үүрэг хүлээлгэх ба хойшлуулшгүй байх үүднээс харьцуулан үзсэний үндсэн дээр хангах ёстой.

43.Олон улсын хамтын ажиллагааны тухайд Тогтвортой хөгжлийн зорилго - 4, Боловсрол 2030 зорилгын Үйл ажиллагааны хүрээтэй уялдан, хоёр талт болон олон талт бүхий л хамтын ажиллагаа нь тэгш хамруулсан, тэгш боломжийг бүрдүүлсэн чанартай боловсролыг хөгжүүлэх, тухайлбал, чадавх бэхжүүлэх дэмжлэг, мэдээлэл хуваалцах, шилдэг туршлагаа солилцох, судалгаа, техникийн, эдийн засгийн туслалцаа, хүртээмжтэй, туслах технологид нэвтрэх боломжтой байх зэргээр хүн бүрд насан туршдаа суралцах боломжийг хөхиүлэн дэмжихэд чиглэх ёстой. Боловсрол талаарх цуглуулсан бүх мэдээлэл, боловсролд зарцуулсан олон улсын бүх туслалцааг хөгжлийн бэрхшээл

¹⁵ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо, Ерөнхий зөвлөмж No. 3.

тус бүрээр ангилан гаргах ёстой. Тогтвортой хөгжлийн зорилго - 4-ийг хэрэгжүүлэх, нотолгоо баримт цуглуулах зорилгоор тэгш хамран сургах боловсролын чиглэлээр олон улсын зохицуулах механизм байгуулах нь илүү сайн бодлогын яриа хэлцэл үүсгэх, ахиц дэвшлээ хянахад хувь нэмэртэй.

IV. Конвенцын бусад заалттай уялдах нь

44.Оролцогч улсууд хүний бүх эрх нь хуваагдашгүй, харилцан хамааралтайг хүлээн зөвшөөрөх ёстой. Боловсрол нь бусад эрхээ бүрэн дүүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэхэд суурь, салшгүй хэсэг болдог.¹⁶ Эсрэгээрээ тэгш хамруулсан сурч боловсрох эрхийг эдлүүлэхийн тулд зарим тодорхой эрхийг заавал биелүүлсэн байх шаардлагатай. Цаашилбал, нийгэм даяараа тэгш хамруулах орчныг бүрдүүлэх нь боловсролд тэгш хамруулах суурийг тавьдаг. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гадуурхах, эрх мэдэлгүй болгоход хүргэдэг нийгмийн саадыг арилгах үүргийг хүлээн зөвшөөрдөг хөгжлийн бэрхшээлийн тухайн хүний эрхийн загварыг батлах, дор дурдсан эрхүүдийн хэрэгжилтийг баталгаажуулсан арга хэмжээ авахыг шаарддаг.

45.Тавдугаар зүйлд хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд тэгш хамгаалуулах зарчмыг зааж өгсөн байдаг. Оролцогч улсууд аливаа хөгжлийн бэрхшээлд тулгуурлан ялгаварлан гадуурхахыг хориглож, ямар нэгэн төрлийн ялгаварлан гадуурхалтаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үр дүнтэй, тэгш хамгаалуулах нөхцөлөөр хангах ёстой. Тогтолцооны болон бүтцийн шинжтэй ялгаварлан гадуурхалтад чиглэж ажиллах, “хууль бүгдэд адил ашигтай байх”-ыг баталгаажуулахын тулд оролцогч улсууд нийтэд зориулсан боловсрол дахь барилга байгууламжийн, харилцаа холбооны, эсвэл бусад саадыг арилгахад чиглэсэн дэмжих арга хэмжээ авах ёстой.

46.Зургаадугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд давхар ялгаварлан гадуурхалтад өртдөг болохыг хүлээн зөвшөөрч, оролцогч улсууд тэдний эрхээ адил тэгш эдлэх нөхцөлийг баталгаажуулах арга хэмжээ авах ёстой. Олон нөхцөлт ялгаварлан гадуурхалт, нийгмээс гадуурхах нь хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийг сурч боловсрох эрхээ эдлэхэд тулгарч байгаа үлэмж саад юм. Оролцогч улсууд жендэрт суурилсан хүчирхийлэл, охид, эмэгтэйчүүд боловсрол эзэмшихийн үнэ цэнийг үл ойшоох гэх мэтчилэн учрах саадыг тодорхойлох, арилгах, жендэр ба/эсвэл хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхах, хэвшмэл ойлголтоор хандах, ухвар мөчид төсөөлөл зэрэг нь сурч боловсрох эрхээ эдлэхэд нөлөөллөөс урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээ авах ёстой. Сурах бичиг, сургалтын хөтөлбөр дэх сөрөг нөлөөтэй жендэр ба/эсвэл хөгжлийн бэрхшээлийн хэвшмэл дүрийг устгах ёстой. Боловсрол нь эцгийн эрхэт ёс, эр хүйс давамгайлсан нийгмийн тогтолцоог бэхжүүлэгч жендэрийн уламжлалт

¹⁶ Мөн тэнд, Суурь боловсролд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөний тухай 1999 оны Ерөнхий зөвлөмж No.11, Ерөнхий зөвлөмж No.13.

ойлголттой тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.¹⁷ Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд өөрийгөө хөгжүүлэх, улам ахиж дэвших, эрх мэдэлжүүлэх арга хэрэгсэл хэмээн үзэж, боловсрол болон нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдахыг баталгаажуулах ёстой.

47.Долоодугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн бүх үйл ажиллагаандаа хүүхдийн дээд ашиг сонирхлыг эн тэргүүнд тооцож, анхаарахыг заасан байдаг. Хүүхдийн дээд ашиг сонирхол гэсэн ойлголт нь хүүхдийн бүх эрхийг бүрэн дүүрэн, үр дүнтэй эдлүүлэх, хүүхдийн цогц хөгжлийг баталгаажуулахад зорьсон билээ.¹⁸ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дээд ашиг сонирхлыг ямар нэг байдлаар тодорхойлохдоо хүүхдийн өөрийн үзэл бодол, хувь хүний онцлог шинж, гэр бүлээ хадгалах, хүүхдийг халамжлах, хамгаалах, аюулгүй байдлыг хангах, ямар нэгэн эмзэг байдалтай эсэхийг анхаарах, хүүхдийн эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох эрхийг хамтатган авч үзэх ёстой. Хүүхдийн эрхийн тухай конвенцод хүүхдийн дээд ашиг сонирхолд тулгуурлан боловсролын бодлого, зохицуулалтыг тодорхойлохоор заасан. Конвенцын 7.3 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд бусад хүүхдийн нэгэн адил өөрсдийн нас болон биеийн онцлогт тохирсон байдлаар өөрт нь хамаарах аливаа асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг эдлүүлэх, хөгжлийн бэрхшээл болон насанд нь тохирсон дэмжлэгийг үзүүлэх ёстойг тайлбарласан байна. Өөрийн эзэмшиж байгаа боловсролдоо хүүхэд өөрөө оролцох эрхийг баталгаажуулах нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нэгэн адил үйлчлэх ба өөрийн суралцах үйл явц, ангид хичээл заах арга зүйн хүрээнд сургалтын ганцаарчилсан төлөвлөгөө хийх, сургуулийн зөвлөлөөр дамжуулан сургуулийн бодлого, тогтолцоог боловсруулах, илүү өргөн хүрээг хамарсан боловсролын бодлого боловсруулахад оролцохыг ойлгоно.¹⁹

48.Наймдугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд, оюуны бэрхшээлтэй хүмүүс, нэлээд их дэмжлэг шаардлагатай хүмүүсийн талаарх хэвшмэл дүр, ташаа ойлголт, сөрөг нөлөө үзүүлэхээр практик үйл ажиллагааны талаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, тэдгээрийг өөрчлөхөд чиглэсэн арга хэмжээ авахыг уриалсан байна. Хэвшмэл дүр, ташаа бодол, сөрөг нөлөө үзүүлэхээр практик үйл ажиллагаа нь боловсролын тогтолцоон дахь хүртээмж, үр дүнтэй суралцах үйл явцад бэрхшээл, саад тотгор үүсгэдэг. Хорооны зүгээс хөгжлийн бэрхшээлийн мөн чанарыг сайн мэдэхгүй, ойлгохгүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ тэгш хамруулсан сургуулиас зарим эцэг эх гаргаж байгааг онцлон тэмдэглэж байна. Оролцогч улсууд нийгмийн амьдралд ялгаатай байдлыг хүндэтгэн, оролцоог хангаж, хүн бүрийг татан оролцуулдаг соёлыг бий болгох,

¹⁷ Эмэгтэйчүүдийн ялгаварлан гадуурхахыг устгах асуудал хариуцсан хороо, “Охид, эмэгтэйчүүдийн сурч боловсрох эрхийн тухай ерөнхий зөвлөмжийн төсөлд зориулсан үзэл баримтгал” (2014).

¹⁸ Хүүхдийн эрхийн хороо, Хүүхэд өөрийн ашиг сонирхлыг эн тэргүүнд анхаарч үзэх эрхийн тухай 2013 оны Ерөнхий зөвлөмж No.14.

¹⁹ Мөн тэнд., Хүүхдийн дуу хоолойг заавал сонсох тухай 2009 оны Ерөнхий зөвлөмж No. 12.

тэгш хамран сургах боловсролыг хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй бүхий л суралцагчид чанартай боловсрол олгох арга арга зам гэж эцэг эх, багш, сургуулийн удирдлага, хамт олон, нийгэмд ойлгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хүндэтгэсэн хандлагыг боловсролын тогтолцооны бүх түвшинд төдийгүй эцэг эх, олон нийтийн дунд бүрдүүлэхийн тулд механизмуудыг бий болгох ёстой. Иргэний нийгэм, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төлөөлсөн байгууллагуудыг аливаа мэдлэг ойлголт нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад татан оролцуулбал зохино.

49.Ес болон хорин дөрөвдүгээр зүйл нь хоорондоо нягт уялдаа холбоотой. Хүртээмжтэй байх нь нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бүрэн дүүрэн, адил тэгш оролцоход зориулсан урьдач нөхцөл юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь сургууль, боловсролын бусад байгууллагыг оролцуулан хүртээмжийг бүрдүүлсэн орчингүйгээр, мөн хүртээмж бүхий нийтийн тээвэр, үйлчилгээ, мэдээлэл, харилцаа холбооны технологигүйгээр тэгш хамрагдан сурч боловсрох эрхээ үр дүнтэйгээр эдэлж чадахгүй болно. Багшлах хэлбэр, арга нь хүртээмжтэй байхын зэрэгцээ хүртээмжтэй орчинд заах шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч суралцах бүхий л орчинг тэгш хамрах боломжийг хөхиүлэн дэмжсэн байдлаар зохион байгуулах ёстой. Тэгш хамран сургах боловсролыг хүртээмж, түгээмэл загварыг хөхиүлэн дэмжих хүчирхэг арга хэрэгсэлд тооцдог.

50.Хороо өөрийн Хуулийн өмнө адил тэгш байх тухай 2014 оны Ерөнхий зөвлөмж No.1-д Оролцогч улсууд анхаарлаа хандуулахыг уриалж, хөгжлийн бэрхшээлтэй, тэр дундаа сэтгэцийн-нийгмийн эсвэл оюуны бэрхшээлтэй суралцагчдад олгож буй тэгш хамран сургах боловсролоор дамжуулан тэдэнд өөрсдийн хүсэл зориг, эн тэргүүний сонирхлоо илэрхийлэх боломж олгодог болохыг тусгайлан анхааруулж байна. Оролцогч улсууд боловсролын бүх түвшинд шаардлагатай дэмжлэгийг үзүүлэн, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг эрх зүйн чадамжаа эдлэхүйц өөртөө итгэх итгэлтэй болгоход тэгш хамран сургах боловсролыг чиглүүлэх ёстой ба хэрэв өөрсдөө хүсвэл цаашид тавих шаардлагыг улам бууруулж болно.

51.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд нь бусад хүний зүгээс хязгаарлуулах, гадуурхагдах, сургуульд ирэх, буцах замдаа дээрэлхүүлэх, боловсролын салбарын ажилтан, алба хаагчдын зүгээс үзүүлэх бие махбодын болон гутаан доромжилсон шийтгэл зэрэг хүчирхийлэл, зүй бус үйлдэлд өртөх илүү их магадлалтай. Конвенцын 16.2 дугаар заалтыг хэрэгжүүлэхийн тулд Оролцогч улсууд бэлгийн хүчирхийлэл гэх мэт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг мөлжих, хүчирхийлэх, зүй бус хандах зэрэг аливаа үйлдлээс хамгаалах, сэргийлэхийн тулд зохистой бүх арга хэмжээг авах шаардлагатай. Тус арга хэмжээг авахдаа нас, жендэр, хөгжлийн бэрхшээлд нь мэдрэмжтэй хандвал зохино. Хороо Оролцогч улсуудад бие махбодын шийтгэл, хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг

доромжлон харьцах бүх хэлбэрийг сургууль зэрэг бүх байгууллагад хориглох, буруутай этгээдэд үр дүнтэй хариуцлага тооцох талаар Хүүхдийн эрхийн хороо, Хүний эрхийн хороо, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос өгсөн зөвлөмжийг сайшаан дэмжиж байна.²⁰ Энэ нь сургууль, боловсролын бусад төвийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй зэрэг бүх суралцагчдыг бодлого боловсруулах үйл явцад, тэр дундаа хүртээмжтэй хамгаалах механизм байгуулах зэрэгт татан оролцуулах, сахилгын арга хэмжээ болон суралцагчдын, ялангуяа хүүхдүүдийн амьдралд улам хүчтэй нөлөөлөх болсон цахим орчинд дээрэлхэх гэх мэтчилэн бүхий л дээрэлхэх үйлдэлд анхаарахыг дэмжин урамшуулдаг.

52.Тэгш хамран сургах боловсрол нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмд бусадтай зэрэгцэн амьдрах, нийгмийн амьдралд тэгш хамруулах, оролцох (19 дүгээр зүйл) эрхийг хүлээн зөвшөөрөхийг шаарддаг. Үүний зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэр бүлтэйгээ амьдрах, боломжгүй тохиолдолд хамт олны дунд хувилбарт үйлчилгээгээр дамжуулан амьдрах адил тэгш эрхийг (23 дугаар зүйл) хүлээн зөвшөөрөхийг шаарддаг. Оролцогч улсын халамжид байгаа, тодруулбал хувилбарт үйлчилгээ эсвэл асрамжийн газарт байгаа хүүхдүүдийн тэгш хамрагдан сурч боловсрох эрх болон тэгш хамран сурах боловсролыг нь үгүйсгэсэн Оролцогч улсын шийдвэрт гомдол гаргах эрхийг баталгаажуулах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй маш олон хүмүүс урт хугацаагаар оршин суудаг тусгаар байгууламжид боловсрол гэх мэтчилэн ямар нэгэн хамт олонд тулгуурласан үйлчилгээ авах боломжгүйгээр, бүр гэр бүлтэйгээ болон хамт олны дунд амьдрах, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх, хүчирхийллээс хамгаалуулах, шударга ёсыг хангуулах эрхээ эдлэх боломжгүй амьдардаг. Орон нутгийн түвшинд тэгш хамран сургах боловсролыг нэвтрүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тусгаар байгууламжид байрлуулж орхидог туршлагыг эцэслэхийн тулд стратегийн шинжтэй хичээл зүтгэл гаргах ёстой (66 дахь догол мөрийг үзнэ үү). Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн өөрийн амьдарч байгаа газраа эрхээ эдлэх, үр шим хүртэх, хувь нэмэр оруулахуйц шаардлагатай хүч чадал, ур чадвар, чадамжийг бий болгох үүргээ биелүүлснээр тэгш хамрагдан сурч боловсрох эрхийг эдлүүлж байна гэж үзвэл зохино.

53.Тэгш хамран сургах боловсролыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бие даасан байдлыг хангах замаар хувийн хөдөлгөөнийг (20 дугаар зүйл) хангах ёстой. Боловсролын байгууллагад очих хүртээмжийг дэмжсэн тээврийн хэрэгсэл хүрэлцээгүй, хувийн туслахгүй тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст, тэр дундаа хараагүй болон харааны бэрхшээлтэй хүмүүст тэдний хараат бус байдлыг хөхиүлэн дэмжих зорилгоор орон зай, баримжааны ур чадвар олгодог зохистой сургалтад хамруулах ёстой. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст боломжийн өртгөөр

²⁰ Мөн тэнд., Бие махбодын шийтгэл, бусад байдлаар хэрцгий эсвэл хүний нэр төрийг доромжлон шийтгэхээс хамгаалуулах эрхийн тухай 2006 оны Ерөнхий зөвлөмж No.8.

хөдөлгөөнийг дэмжих хэрэгсэл, хэрэглэгдэхүүнийг олж авах боломжоор хангах ёстой.

54.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ямар нэгэн алагчлалгүйгээр аль болох эрүүл мэндийн дээд түвшний стандартаар хангуулах эрхээ (25 дугаар зүйл) эдлэх нь боловсролоос бүрэн дүүрэн үр шим хүртэх боломжтой салшгүй холбоотой. Эрүүл мэндийн үйлчилгээ эсвэл тохиромжтой эмчилгээ, халамж авах боломжгүй тохиолдолд боловсролын орчинд оролцох, үр дүнтэй суралцах чадварт сөргөөр нөлөөлнө. Оролцогч улсууд жендэрийн үүднээс тусгайлан анхаарч эрүүл мэнд, ариун цэвэр, шим тэжээлийн хөтөлбөрийг боловсролын үйлчилгээтэй уялдуулан батлах, эрүүл мэндтэй холбоотой аливаа хэрэгцээг тасралтгүй хянах шаардлагатай. Тогтмол байдлаар эмчийн үзлэг хийх, эрүүл мэндийн хяналт тавих, олон нийтийн түншлэлийг бий болгохын тулд дээрх хөтөлбөрийг түгээмэл загвар болон хүртээмжтэй байх зарчимд тулгуурлан боловсруулбал зохино. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусдын нэгэн адил шинжлэх ухааны нотолгоо, хүний эрхийн стандартад тулгуурласан, насны онцлогт тохируулсан, цогц шинжтэй, тэгш хамруулсан бэлгийн цогц боловсролыг хүртээмжтэй байдлаар олгох ёстой.

55.Оролцогч улсууд эрүүл мэнд-халамжийн, сэргэн засах, биеийн тамирын, нийгмийн ажил үйлчилгээ, зөвлөх болон бусад үйлчилгээг багтаасан боловсролын тогтолцоон дахь нийгэмшүүлэх, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэх (26 дугаар зүйл) үр дүнтэй арга хэмжээ авах ёстой. Эдгээр үйлчилгээг сурагчийн давуу талыг илрүүлэх зорилготой олон салбарын нэгдсэн үнэлгээнд тулгуурлан аль болох эрт наснаас эхлүүлэх нь зүйтэй ба хамгийн дээд түвшинд хараат бус, бие даасан байдлыг нь хангах, хүний эрхэм чанарыг хүндэтгэх, бие махбодын, сэтгэцийн, нийгмийн, мэргэжлийн ур чадварыг нь бүрэн дүүрэн хөгжүүлэх, амьдралын бүх хүрээнд тэгш хамруулах, оролцуулахад дэмжлэг үзүүлэх зорилготой байх ёстой. Хороо нь эрт илрүүлэхэд анхаардаг, үе тэнгийн дэмжлэгийг урамшуулдаг хамт олонд түшиглэн нөхөн сэргээх үйл явцыг дэмжих нь чухал ач холбогдолтойг онцолж байна.

56.Чанартай тэгш хамран сургах боловсрол нь нээлттэй хөдөлмөрийн зах зээлд болон нээлттэй, тэгш хамруулсан, хүртээмжтэй хөдөлмөрлөх орчинд оролцоход шаардлагатай мэдлэг, ур чадвар, өөртөө итгэх итгэлийг олж авах замаар хөдөлмөрлөх амьдралд (27 дугаар зүйл) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бэлтгэх ёстой.

57.Тэгш хамрагдан сурч боловсрох эрхийг хэрэгжүүлснээр улс төрийн болон нийтийн амьдралд бүрэн дүүрэн оролцох явдлыг улам нэмэгдүүлэх болно. Бүх суралцагчдад зориулсан сургалтын хөтөлбөр нь иргэншлийн тухай сэдэв, улс төр, нийгмийн үйл явцад оролцох тулгуур үндэс болсон өөрийгөө төлөөлөх, өөрийн төлөө нөлөөллийн ажил хийх чадварыг багтаах ёстой. Нийтийн үйл хэрэг гэдэгт оюутны зөвлөл зэрэг суралцагчдын байгууллага байгуулах, оролцохыг хэлэх ба Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгосон харилцаа холбоо, хэлээр дамжуулан тухайн суралцагчдын байгууллагыг байгуулах, элсэх,

үр дүнтэй, бүрэн дүүрэн оролцох таатай орчныг (29 дүгээр зүйл) хөхиүлэн дэмжвэл зохино.

58.Оролцогч улсууд боловсролын бусад орчинд, мөн боловсролын тогтолцоонд болон хичээлээс гадуурх үйл ажиллагаанд бусдын нэгэн адил оролцох, тухайлбал, тоглож наадах, спортоор хичээллэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарах саад тогторыг арилгах, тэдэнд зориулсан тэгш хамруулах боломжийг хүртээмжтэй, хүрэлцээтэй байхуйцаар (30 дугаар зүйл) хөхиүлэн дэмжих ёстой.²¹ Дан ганц өөрийн тусын тулд төдийгүй нийгмээ улам баялаг болгох үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн соёлын амьдралд оролцох, өөрийн бүтээлч, урлагийн, оюуны чадавхаа хөгжүүлэх, сайжруулах боломжийг баталгаажуулсан боловсролын орчныг бий болгохоор зохистой арга хэмжээг авах ёстой. Тус арга хэмжээнд дохионы хэл, дүлий хүмүүсийн соёлыг зэргийг багтаан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн соёлын болон хэлний онцлох шинжийг хүлээн зөвшөөрүүлэх эрхийг баталгаажуулах ёстой.

V. Үндэсний түвшинд хэрэгжүүлэх

59.Хороо Оролцогч улсуудын зүгээс 24 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхэд цөөнгүй бэрхшээлтэй тулгарч байгааг тогтоосон билээ. Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнд зориулсан тэгш хамран сургах боловсролын тогтолцоог бий болгох, хөгжүүлэхийн тулд үндэсний түвшинд дор дурдсан арга хэмжээг авбал зохино.

60.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст төдийгүй бусад бүх хүмүүст бүх түвшний боловсрол олгох нь боловсролын яамны хариуцах үүрэг хариуцлага байх ёстой. Цөөнгүй улсад хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсролыг нийгэм хамгааллын эсвэл эрүүл мэндийн яам хариуцахаар тодорхойлсноороо тэднийг улам гадуурхаж, үүний дүнд боловсролтой холбоотой хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө боловсруулах, нөөц бүрдүүлэхдээ анхаарч тусгахгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролд зарцуулах нэг хүнд ногдох хэмжээг маш багаар тогтоох, тэгш хамран сургах боловсролыг дэмжихүйц салбар хоорондын, уялдаа холбоотой бүтэцгүй байх, шинээр элссэн, улирсан, ахисан тухай нарийвчилсан мэдээлэл цуглуулахгүй, мөн тэгш хамруулсан багшийн боловсролыг хөгжүүлэхгүй орхигдуулж байна. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын боловсролыг боловсролын яамны бүрэн эрхэд шууд хамааруулах арга хэмжээг даруй авах ёстой.

61.Оролцогч улсууд Засгийн газраар дамжуулан тэгш хамруулан боловсрол олгохын тулд цогц, салбар хоорондын шинжтэй хичээл зүтгэл гаргахаа баталгаажуулах ёстой. Конвенцын үндэслэл бүхий зүйл заалтын дагуу хариуцлага хүлээсэн холбогдох бүх яам, комисс тэгш хамран сургах боловсролын тогтолцооны утга учрын талаарх ойлголтоо нэгтгэж, хамтаараа хэрэгжүүлэх төлөвлөгөөг биелүүлэхийн тулд

²¹ Мөн тэнд., Хүүхдийн амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх, тоглох, наадах, урлаг, соёлын амьдралд оролцох эрхийн тухай 2013 оны Ерөнхий зөвлөмж No.17.

нэгдмэл байдлаар хандаж, цугтаа ажиллахаар хичээн зүтгэх ёстой. Үүрэг хүлээсэн бүх яамны хариуцлагын арга хэмжээнд мөн туссан байх ёстой. Үйлчилгээ үзүүлэгч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төлөөлсөн байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагууд, орон нутгийн захиргаа, суралцагчдын нийгэмлэг, холбоо, их сургууль, багшийн боловсрол олгох коллеж зэрэг байгууллагууд хоорондоо түншилбэл зохино.

62.Оролцогч улсууд бүхий л түвшинд 24 дүгээр зүйлтэй бүрэн нийцсэн байдлаар хөгжлийн бэрхшээлийн тухай хүний эрхийн загварт тулгуурлан хууль тогтоомжоо гаргаж хэрэгжүүлэх ёстой. Хорооны зүгээс 4.5 дугаар зүйлийн дагуу холбооны Улсууд 24 дүгээр зүйлийг ямар нэгэн хязгаарлалт эсвэл хасалтгүйгээр Оролцогч улсын бүх хэсэгт хэрэгжүүлэх ёстойг дахин сануулж байна.

63.Тэгш хамран сургах боловсролд зориулсан уялдаа холбоо бүхий цогц хууль тогтоомжийн болон бодлогын хүрээ нь хэрэгжүүлэх цаг хугацааны хүрээг ойлгомжтой, зохистой байдлаар тодорхойлсон байхын хамт зөрчсөн тохиолдолд тооцох хариуцлагын хамт тусгасан байх ёстой. Энэхүү хүрээгээр уян хатан, ялгаатай болон тэгш байдалд хамаарах асуудлыг шийдвэрлэхдээ бүх суралцагчдад хамаарах боловсролын бүх байгууллагад үйлчлэхээр боловсруулах, төрийн бүх түвшинд хүлээх хариуцлагыг тодорхойлох ёстой. Гол бүрэлдэхүүн хэсэгт дараах зүйлийг багтаана. Үүнд:

- (a) Хүний эрхийн олон улсын стандарттай нийцсэн байх;
- (b) Тэгш хамруулах талаар ойлгомжтой тодорхойлох, боловсролын бүх түвшинд үүнийг бий болгохын тулд нарийвчилсан зорилттой байх. Тэгш хамруулах зарчим, үйл ажиллагаа нь шинэчлэлийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг байхаас нэмэлт хөтөлбөр байдлаар боловсруулж огт болохгүй;
- (c) Тэгш хамрагдан сурч боловсрох тулгуур эрх нь хууль тогтоомжийн бүрэлдэхүүн хэсэг байна. Жишээлбэл “боловсрол олгох боломжгүй” гэж зарим суралцагчдыг ангилсан заалт байвал шууд халах ёстой;
- (d) Хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй суралцагчдын тэгш хамруулан суралцах боломжтой байх эрхийг, мөн хувь суралцагчдын тухайд бүхий л түвшинд шаардлагатай дэмжих үйлчилгээ авах боломжийг нэгэн адил баталгаажуулах;
- (e) Бүх шинэ сургуульд хүртээмжтэй байх стандартыг удирдлага болгон түгээмэл загварын талаарх зарчмын дагуу шаардлага тавих, Хорооны зүгээс гаргасан Ерөнхий зөвлөмж No.2-той уялдуулан одоо ажиллаж байгаа сургуулиудаа дээрх шаардлагад нийцүүлэх цаг хугацааны хязгаарыг тавьж шаардах. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлэх;
- (f) Тэгш хамран сургах боловсролын цогц чанарын стандарт, мөн бүх түвшинд хэрэгжүүлэхдээ гаргасан дэвшлийг хянах, түүнчлэн

бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн, хангалттай хөрөнгө оруулалт авсан байх үүднээс хөгжлийн бэрхшээлд тулгуурласан-тэгш хамруулсан хяналт-шинжилгээний механизмыг нэвтрүүлэх;

(g) Бодлого хэрэгжүүлэх, хангалттай хөрөнгө оруулалт хийхийг баталгаажуулахын тулд хүртээмжтэй хяналт-шинжилгээний механизмыг нэвтрүүлэх;

(h) Нөөцийг үр өгөөжтэй зарцуулах гэхээс илүүтэйгээр хүний эрхийн стандартад тулгуурлан, тэгш хамруулах явдлыг дэмжихийн тулд тохируулгат хэрэглэгдэхүүний хэрэгцээг хүлээн зөвшөөрөхийн хамт тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангаагүй тохиолдолд тооцох хариуцлагыг тусгайлан заах;

(i) Тэгш хамран сургах боловсролд үр нөлөө үзүүлэх боломжтойг баталгаажуулж, тэгш хамруулах нь бодит зорилго гэдгийг ойлгомжтойгоор бүх хууль тогтоомждоо заах;

(j) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэгш хамруулсан суралцах орчинд улам чадавхжихад шаардлагатай эрт илрүүлэх, үнэлэх, үзүүлэх дэмжлэгийг багтаасан үйл ажиллагааны иж бүрэн хүрээтэй байх;

(k) Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг хамруулан бүх суралцагчдыг тэгш хамруулсан орчин, анги, тэр дундаа хамгийн тохиромжтой хэл, хүртээмжтэй нөхцөл, хэлбэр, харилцааны арга хэрэгслээр хэрхэн хангахыг төлөвлөх, хэрэгжүүлэх асуудлыг орон нутгийн удирдлага хариуцах;

(l) Сургуулийн зөвлөл, удирдах зөвлөл, орон нутгийн болон үндэсний засгийн газарт болон боловсролын тогтолцоонд гомдол гаргах механизмаар дамжуулан боловсролтой холбоотой шийдвэрийг эсэргүүцэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс дуу хоолойгоо сонсгох, өөрийн байр суурьтай байх эрхийг баталгаажуулсан хууль тогтоомжтой байх;

(m) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний төлөөллийн байгууллага, харилцан адилгүй агентлаг, хөгжлийн байгууллага, төрийн бус байгууллага, эцэг эх, асран хамгаалагчийг багтаан оролцогч бүх талуудын дунд түншлэл, зохицуулалтыг бий болгох.

64.Хууль тогтоомж нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай зөвшилцөн боловсруулсан, тэгш хамран сургах боловсролын тогтолцоог бий болгох үйл явцыг нарийвчлан тусгасан боловсролын салбарын төлөвлөгөөгөөр дэмжигдсэн байх ёстой. Төлөвлөгөө нь цаг хугацааны хүрээтэй, уялдаа холбоог хангах арга хэмжээг багтаасан хэмжигдэхүйц зорилготой байна. Төлөвлөгөө нь одоогийн төсвийн хуваарилалт, мэдээлэл цуглуулах аргын чанар, сургуулийн гадна байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, бэрхшээл, саад тотгор, одоогийн хүчин төгөлдөр хууль тогтоомж, бодлого, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүл, Оролцогч улсын санаа зовоосон гол асуудал зэргийг багтаасан мэдээллийн сан бүхий ахиц дэвшлийг хэмжих гарааны үнэлгээ болохуйц тэгш хамран

сургах боловсролын өнөөгийн нөхцөл байдлын цогц дүн шинжилгээн дээр суурилсан байна.

65.Оролцогч улсууд сурч боловсрох эрх зөрчигдсөн тохиолдолд хандаж болох хараат бус, үр дүнтэй, хүртээмжтэй, ил тод, аюулгүй, хэрэгжихүйц гомдлын механизмыг эрх сэргээх, хохирол барагдуулах үйл явцын хамт бий болгох ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүн нь тэдэнд хэрхэн үйлчлэхээ мэддэг, хөгжлийн бэрхшээлтэй холбоотой нэхэмжлэл гаргах боломжтой шударга ёсны тогтолцоонд хандах боломжтой байх ёстой. Оролцогч улсууд тэдний төлөөллийн байгууллагыг оролцуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан сурч боловсрох эрхийн тухай, мөн тус эрхэд халдсан эсвэл зөрчсөн тохиолдолд хэрхэн тэмцэх талаарх мэдээллийг өргөн хүрээтэй түгээн дэлгэрүүлэх, нийтэд түгээх ёстой.

66.Тэгш хамран сургах боловсрол нь тусгаарлах байгууламжтай зохицохгүй. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгаарлах байгууламжийг байхгүй болгох үйл явцыг үе шаттайгаар сайтар төлөвлөж хийх ёстой. Шилжилт хийх хугацааг тодорхойлох, олон нийтэд тулгуурласан үйлчилгээг бий болгох эрх зүйн хүрээг боловсруулах, санхүүжилтийг өөрчлөн хуваарилах, олон нийтэд тулгуурласан үйлчилгээг дэмжих, бэхжүүлэхийн тулд салбар хоорондын үйл ажиллагааны хүрээг тодорхойлох, гэр бүлд зориулсан дэмжлэгийг бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчийг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийн байгууллагатай хамтран ажиллах, зөвлөлдөх зэрэг үйл явц өрнөнө. Тусгаарласан байгууламжийг үгүй хийх үйл явц үргэлжилж байх хугацаанд тухайн байгууламжид амьдарч байгаа хүмүүст тэгш хамрагдан сурч боловсрох боломж олгохын тулд тухайн нийгэм дэх тэгш хамруулсан академик байгууллагатай даруй холбогдвол зохино.

67. Бага насны хүүхдийн халамж, үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үнэлж баршгүй ач холбогдолтой бөгөөд боловсролоос үр шим хүртэх чадавхыг бэхжүүлэх, тэдний сургуульд элсэн сурах, тасралтгүй үргэлжлүүлэн сурахад тустай билээ. Дээрх үйл ажиллагаа нь хүүхдийн эрхэм чанар, бие даасан байдлыг хүндэтгэсэн байх ёстой. Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилгыг оролцуулан Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх хөтөлбөртэй уялдуулан Оролцогч улсууд сургуулийн өмнөх насанд хүүхэд хөгжих, халамж авах, сургуулийн өмнөх чанартай боловсрол эзэмших боломжийг төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдыг дэмжих, сургах боломж нөхцөлийг баталгаажуулах үүрэгтэй. Аль болох эрт илрүүлж, дэмжсэн тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхэд сургуулийн өмнөх болон сургуулийн түвшний тэгш хамруулсан боловсролын байгууллагуудын хооронд хялбархан шилждэг ажээ. Оролцогч улсууд холбогдох бүх яам, албан тушаалтан, этгээд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага, төрийн бус байгууллагын хоорондын зохицуулалтыг баталгаажуулах ёстой.

68.Конвенцын 31 дүгээр зүйлд заасны дагуу Оролцогч улсууд 24 дүгээр зүйлд заасан өөрийн үүргээ биелүүлэхийн тулд бодлого, төлөвлөгөө,

хөтөлбөр боловсруулахдаа ашиглах нарийвчилсан мэдээллийг цуглуулах ёстой. Мөн харилцан адилгүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх тодорхой тоон мэдээлэлгүй, мөн хангалттай тооны чанарын судалгаагүй, боловсролд хамрагдалт, хүртээмж, үргэлжлүүлэн суралцах байдал, гарч байгаа ахиц дэвшил, тохируулгат хэрэглэгдэхүүний хангамж, холбогдох үр дүнгийн талаарх мэдээлэлгүй байгааг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээг нэвтрүүлэх ёстой. Хүн амын тооллого, асуулга, захиргааны тоо, мэдээлэл, Боловсролын удирдлагын мэдээллийн тогтолцооноос гарах мэдээлэл аль аль нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тухай мэдээллийг, тусгаарласан байгууламжид амьдарч байгаа хүмүүсийг оролцуулан гаргах ёстой. Оролцогч улсууд цаашид үр нөлөөтэй арга хэмжээ авч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэгш хамруулсан чанартай боловсрол эзэмших, үргэлжлүүлэн суралцах, дэвшил гаргах боломжийг бүрдүүлэхийн тулд тулгарч байгаа саад тотгорын талаарх нарийвчилсан мэдээлэл, нотлох баримт цуглуулбал зохино. Эцэг эхчүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийнхээ оршихуйг хүлээн зөвшөөрөхгүй үгүйсгэх, төрсний гэрчилгээгүй байх, тусгаарласан байгууламжид үл үзэгдэх байдлаар амьдарч байгаа зэргээс шалтгаалан тоон болон чанарын мэдээлэл цуглуулдаг стандарт механизмаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гадна үлдэж байгааг шийдвэрлэх зорилгоор стратегиудыг батлах ёстой.

69.Оролцогч улсууд ахиц дэвшилттэй хэрэгжүүлэх зарчимд нийцүүлэн тэгш хамруулан боловсрол олгох явцыг дэмжихийн тулд боловсролын салбарын төлөвлөгөө, салбар хоорондын төлөвлөгөө боловсруулахдаа хангалттай санхүүгийн болон хүний нөөц зориулах ёстой. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний сурч боловсрох эрхийг баталгаажуулахын тулд өөрийн засаглалын тогтолцоо, санхүүжилтийн механизмыг шинэчлэх ёстой. Төрийн худалдан авах ажиллагааны үйл явц болон хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд боломжит механизмаа ашиглан төсвийг хуваарилах нь зохистой. Товлосон хугацааны дотор одоо байгаа боловсролын байгууллагаа хүртээмжтэй болгон өөрчлөх, тэгш хамруулсан багшийн боловсролд хөрөнгө оруулах, боломжтой тохируулгат хэрэглэгдэхүүнийг хийх, сургуулийг хүртээмжтэй тээврийн хэрэгслээр хангах, тохиромжтой, хүртээмжтэй сурах бичиг, заах, сургах материал боловсруулах, туслах технологи, дохионы хэлээр хангах, доромжлон гутаах, ялгаварлан гадуурхахын эсрэг мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх санаачилга өрнүүлэх, ялангуяа боловсролын байгууллагад дээрэлхэхийн эсрэг чиглэсэн үйл ажиллагааг эхний ээлжинд эрэмбэлэн хангалттай нөөцийг хуваарилах ёстой.

70.Хороо Оролцогч улсуудаас тусгаарласан орчноос тэгш хамруулсан орчин бий болгоход зориулан нөөцөө шилжүүлэн зарцуулахыг уриалж байна. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шаардлагатай дэмжлэг үзүүлэхийн тулд тэгш хамруулсан боловсролын орчинг бий болгохоор нөөц хуваарилдаг, урамшуулдаг санхүүжилтийн загвар хөгжүүлбэл зохино. Санхүүжилтэд баримтлах хамгийн тохиромжтой хандлагаа тодорхойлохдоо одоогийн байгаа боловсролын орчин, тухайн

орчин дахь боломжит хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдаас үүдэлтэй шаардлагыг анхаарч үзнэ.

71. Сургуулийн өмнөх, бага, дунд, дээд, мэргэжлийн боловсролын түвшний бүх багшийг сургах үйл явц нь тэдэнд тэгш хамруулсан боловсролын орчинд ажиллахад шаардлагатай үндсэн чадамж, үнэт зүйлийг олгоход чиглэсэн байх ёстой. Тухайн үйл явц нь ажилд гарахын өмнөх болон ажлын байран дээрх мэргэжил дээшлүүлэх сургалтаа аль болох богино хугацаанд зохих чадварыг эзэмших түвшинд хүрэхүйц хэлбэрээр тохируулан өөрчлөхийг шаардах ба тэгш хамран сургах боловсролын тогтолцоо руу хийх шилжилтийг хялбаршуулж өгнө. Бүх багшид тэгш хамруулахтай холбоотой янз бүрийн бэрхшээлээр дамжуулан асуудлыг шийдэх ур чадвар олгох, итгэх итгэлтэй болгохуйц бодит туршлага олгохоор сургалтын байгууллагад дадлага хийх, турших боломж олгохын зэрэгцээ тэгш хамруулсан байгууллагад ажиллахад тэднийг бэлтгэхэд зориулсан сургалтын нэгж/модулиар хангах ёстой. Багшийн боловсролын гол агуулга нь хүний ялгаатай байдал, өсөлт, хөгжил, хөгжлийн бэрхшээлийн тухай хүний эрхийн загвар, багш тэгш хамруулсан боловсролын орчинд суралцагчид оролцох нөхцөлийг хангадаг суралцагчдын гүйцэтгэх чадварыг (хүч чадал, чадвар, сурах арга барил) тодорхойлох боломж олгодог тэгш хамруулсан заах арга зүйг чухалчлан ойлгуулахад чиглэнэ. Багшийн боловсрол нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжих Брайл үсэг, томоор хэвлэх, хүртээмжтэй мультимедиа материал, хялбар унших, энгийн үгээр илэрхийлэх, дохионы хэл, дүлий хүмүүсийн соёл, боловсрол сургалтын арга зүй, материал зэрэг зохих нэмэлт болон хувилбарт горим, харилцааны арга хэрэгсэл, хэлбэрийг ашиглах талаар заана. Үүний зэрэгцээ ганцаарчилсан хичээл заах; хүн бүрийн суралцах арга барил, ялгаатай чадварт тааруулан харилцан адилгүй аргаар нэг ижил агуулгыг заах; суралцах тусгай шаардлагыг дэмжиж ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, ашиглах; суралцагчдын боловсролын зорилгод төвлөрсөн арга зүйн талаар багш нарт практик удирдамж, дэмжлэг шаардлагатай.

72. Тэгш хамран сургах боловсрол нь боловсролын байгууллагын бүх түвшинд багш нарт чиглэсэн дэмжлэг үзүүлэх, нөөцөөр хангах тогтолцоо шаарддаг. Уг тогтолцоонд багаар багшлах, суралцах бүлэг, суралцагчийг хамтран үнэлэх үйл явц, үе тэнгийнхний дэмжлэг, туршлага судлах аялал, иргэний нийгэмтэй түншлэх гэх мэтчилэн хамтран ажиллах байдлыг хөхиүлэн дэмжсэн байхын зэрэгцээ их сургууль, зэргэлдээ орших боловсролын байгууллагуудын хоорондын түншлэл ч багтана. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын эцэг эх, асран хамгаалагч шаардлагатай тохиолдолд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө болон бусад сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд түншлэн ажиллах боломжтой. Тэд тухайн суралцагчдыг дэмжихийн тулд багшид зөвлөх, дэмжих чухал үүрэг гүйцэтгэж болох ч боловсролын тогтолцоонд элсэн ороход зайлшгүй тавигдах нөхцөл болохгүй. Оролцогч улсууд үе тэнгийнхэн бие биендээ зөвлөх, түншлэх, асуудал шийдвэрлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах боломжтой хөгжлийн

бэрхшээлтэй хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын төлөөллийн байгууллага, орон нутгийн иргэд зэрэг багшийг дэмжих бүхий л нөөцөө дайчлах нь зүйтэй. Мөн тэдний оролцоо нь анги танхимд нэмэлт нөөц болж, орон нутгийн хүмүүстэй холбоо тогтоох, саад тотгорыг арилгах, багшийг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын давуу тал, шаардлагад мэдрэмжтэй хандаж, хариу үйлдэл илүү сайн үзүүлэхэд хувь нэмрээ оруулж чадна.

73. Бүх түвшний албан тушаалтан тэгш хамран сургах боловсролыг дэмжих зорилгоор хууль, бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх чадавх, хичээл зүтгэл, нөөц гаргах ёстой. Оролцогч улсууд холбогдох бүх албан тушаалтны хуулиар хүлээсэн үүргийн талаар таниулах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай ойлголт нэмэгдүүлэх сургалтыг боловсруулах, орох явдлыг баталгаажуулах ёстой. Тэгш хамруулсан бодлого, туршлага хэрэгжүүлэхэд шаардлагатай чадвар, мэдлэг, ойлголтод тэгш хамрагдан сурч боловсрох эрхийн тухай ойлголтыг танин мэдэх, түүний зорилго, холбогдох олон улсын болон үндэсний хууль тогтоомж, бодлогын талаарх мэдлэг, орон нутгийн түвшний тэгш хамруулсан боловсролын төлөвлөгөө боловсруулах, хамтран ажиллах, түншлэх, орон нутгийн боловсролын байгууллагаа дэмжих, зааварлах, хянах, хяналт-шинжилгээ хийх, үнэлэх зэрэг багтана.

74. Чанартай тэгш хамран сургах боловсрол нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад тулгарч байгаа саад тотгорыг анхаарсан суралцагчдын ахиц дэвшлийг хянах, хяналт-шинжилгээ хийх арга зүйг шаарддаг. Суралцагч болон сургуулийн амжилтыг стандартчилсан шалгалтын онооны ахиц гэсэн ганцхан шалгуураар үнэлдэг үнэлгээний уламжлалт тогтолцоо нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад сул тал бий болгох талтай. Өргөн хүрээг хамарсан зорилгод хүрэхийн тулд хувь хүний түвшинд гарсан дэвшлийг чухалчлан үзэх ёстой. Тохиромжтой багшлах арга зүй, дэмжлэг, хэрэглэгдэхүүнээр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй зэрэг бүх суралцагчийн хэрэгцээнд нийцсэн байдлаар сургалтын хөтөлбөрөө нийцүүлж өөрчилж болно. Тэгш хамрагдан суралцаж буй суралцагчийн үнэлгээний тогтолцоо нь ганцаарчилсан дэмжлэгийн тогтолцоогоор улам сайжрах боломжтой.

75. Конвенцын 33 дугаар зүйлийн дагуу тэгш хамран сургах боловсролын тогтолцоог бий болгох замаар сурч боловсрох эрхийг биелүүлж байгаа дэвшилээ хэмжихийн тулд Оролцогч улсууд Тогтвортой хөгжлийн зорилго - 4-тэй уялдуулан бүтцийн, үйл явцын, гарцын шалгуур үзүүлэлт, тухайн шалгуур үзүүлэлт бүрт тохирсон тусгай хэмжүүр, зорилго бүхий хяналт-шинжилгээний хүрээг боловсруулах ёстой.²² Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, төлөөллийн байгууллагаараа дамжуулан шалгуур үзүүлэлтийг тогтох, мэдээлэл, статистик цуглуулахад нэгэн адил оролцвол зохино. Бүтцийн шалгуур үзүүлэлт нь тэгш хамран сургах боловсролд тулгарч буй саад тотгорыг хэмжих ба хөгжлийн бэрхшээлээр ангилсан нарийвчилсан мэдээлэл цуглуулахаар

²² НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар, *Хүний эрхийн шалгуур үзүүлэлт: Хэмжих, хэрэгжүүлэх заавар (Нью-Йорк, Женев хот, 2012 он)*.

хязгаарлахгүй. Үйл явцын шалгуур үзүүлэлт нь бодит орчны хүртээмж, сургалтын хөтөлбөрийг нийцүүлсэн байдал эсвэл багшийн сургалт зэрэг тухайн хувиран өөрчлөгдөж байгаа дэвшлийг хянан шинжлэх боломж бүрдүүлнэ. Гарцын шалгуур үзүүлэлт нь төгсөлтийн гэрчилгээ эсвэл диплом авах тэгш хамруулсан сургалтын орчинд суралцдаг суралцагчдын хувь эсвэл ерөнхий боловсролын сургуульд элссэн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хувь зэргийг тогтоох ёстой. Оролцогч улсууд жишээлбэл, хүний эрхийг хүндэтгэх, тэгш боломж, хамааралтай байдал, зохимжтой байдал, үр өгөөж, үр ашиг гэсэн НҮББШУСБ-ын зөвлөсөн таван хэмжигдэхүүнийг боловсролын чанарыг хэмжихдээ харгалзаж болно. Квот тогтоох, урамшуулалт хөшүүрэг бий болгох зэрэг дэмжсэн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж болно.

76. Хороо цөөнгүй улсад боловсрол салбарт хувийн хэвшлийн оролцоо өсөн нэмэгдэж байгааг тэмдэглэж байна. Оролцогч улсууд тэгш хамрагдан сурч боловсрох эрх нь гагцхүү төрийн боловсролын тогтолцоонд биш бүх боловсролын хэвшилд хамаатай болохыг хүлээн зөвшөөрөх ёстой. Оролцогч улсууд бизнесийн салбар зэрэг гуравдагч талын зүгээс эрх зөрчихөөс хамгаалсан арга хэмжээ авах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг үр дүнтэй эдлүүлэх, хэрэгжүүлэхэд бизнесийн аж ахуйн нэгжийн үзүүлэх нөлөөг хүрээлэх бодлогыг батлах, шаардлагатай бол хууль тогтоомж, зохицуулалт, хяналт-шинжилгээ хийх, хянах, сахиулах мөрдөх, сурч боловсрох эрхийн үүднээс тэгш хамруулсан боловсрол олгох байдлыг баталгаажуулах үүргийг хүлээлгэх арга хэмжээг авах ёстой. Боловсролын байгууллага, хувийн хэвшлийн боловсролын байгууллага, аж ахуйн нэгж хүртээмжийг бий болгох болон/эсвэл тохируулгат хэрэглэгдэхүүн бий болгосны төлөө нэмэлт төлбөр авч болохгүй.
